

# “ИРГЭНИЙ ОРОН ЗАЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ” СУДАЛГАА

дэлгэрэнгүй тайлан

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ГАРЧИГ

Судалгааны хүснэгт, зургийн жагсаалт .....	3
Судалгааны баг .....	5
Товчилсон үгийн жагсаалт .....	6
Удиртгал .....	7
<b>БҮЛЭГ 1. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛ, ЧИГЛЭЛ.....</b>	<b>8</b>
1.1.    ТББ-ын төрөл, хэлбэр .....	8
1.1.1.    ТББ-ын төрөл хэлбэрийн талаарх зохицуулалт .....	8
1.1.2.    ТББ-ын хэлбэр, тэдгээрийн тоо хэмжээ.....	11
1.2.    ТББ-ын үйл ажиллагааны салбар, чиглэл.....	13
1.2.1.    Үйл ажиллагаанд тулгамддаг саад бэрхшээл .....	17
<b>БҮЛЭГ 2. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХИ .....</b>	<b>20</b>
2.1.    Үүсгэн байгуулагчид ба удирдах зөвлөл.....	20
2.1.1.    Гишүүнчлэл .....	23
2.1.2.    Гүйцэтгэх удирдлага ба сайн дурын ажилтан.....	24
2.2.    ТББ-ын санхүүжилт, татвар .....	27
2.2.1.    ТББ-ын зардал ба хөрөнгө.....	27
2.2.2.    Төрийн бус байгууллагын орлого ба санхүүжилт .....	30
2.2.3.    ТББ-ын хуримтлал.....	33
2.2.4.    ТББ-ын татвар ба хөнгөлөлт чөлөөлөлт.....	34
2.3.    ТББ-ын тайлagnалт .....	36
2.4.    ТББ-ын хамтын ажиллагаа .....	38
<b>БҮЛЭГ 3. ТББ-ЫН ҮР НӨЛӨӨ .....</b>	<b>44</b>
<b>БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ ОРОН ЗАЙ .....</b>	<b>52</b>
4.1.    Иргэний суурь эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн үнэлгээ.....	52
4.2.    ИНБ-ын эрх, эрх чөлөөний талаарх ТББ-ын үнэлгээ.....	53
4.3.    ТББ-ын талаарх иргэдийн санаа бодол.....	61
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>65</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....</b>	<b>70</b>
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>73</b>
Судалгааны хүрээ, арга зүй .....	734
Тоон судалгааны аргачлал .....	74
Чанарын судалгааны аргачлал .....	75
Судалгааны үр дүнгийн хүснэгт (хавсралт 1-10).....	79

## ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ТББ-уудыг тодорхойлсон байдал .....	8
Хүснэгт 2. ТББ-уудын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар .....	13
Хүснэгт 3. Байгууллагын үйл ажиллагааны хэлбэр, засаг захирагааны түвшнээр .....	16
Хүснэгт 5. Орлогын эх үүсвэр, байршилаар, хувиар .....	31
Хүснэгт 6. Орлогын эх үүсвэр, байгууллагын төрлөөр, хувиар .....	32
Хүснэгт 7. Санхүүгийн эрсдэлээс хамгаалсан хуримтлалтай эсэх, үйл ажиллагааны хэлбэрээр, хувиар .....	33
Хүснэгт 8. 2019 онд төлсөн татварын дундаж хэмжээ, байгууллагын төрлөөр, төгрөгөөр, хувиар .....	35
Хүснэгт 9. 2019 онд төлсөн татварын дундаж хэмжээ, байршилаар, төгрөгөөр .....	35
Хүснэгт 10. 2019 онд төлсөн НДШ-ийн дундаж хэмжээ, байгууллагын төрлөөр, төгрөгөөр .....	35
Хүснэгт 12. Хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн татварын төрөл, байршилаар, төгрөгөөр .....	35
Хүснэгт 13. Хөнгөлөлт чөлөөлөлт эдэлсэн татварын төрөл, дундаж хэмжээ, байгууллагын төрөл, төгрөгөөр .....	36
Хүснэгт 14. Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, хувиар .....	38
Хүснэгт 15. Төрөөс үзүүлдэг тусламж дэмжлэгт өгч буй дундаж үнэлгээ, / 1-5 онооны шкалаар / .....	40
Хүснэгт 16. ТББ-ын үйл ажиллагаа явуулдаг зорилтот бүлэг, үйл ажиллагааны хэлбэрээр /олон сонголттой хариултаар/ .....	44
Хүснэгт 17. Үр нөлөө, байршилаар .....	45
Хүснэгт 18 Иргэний суурь эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд ТББ-уудын өгсөн үнэлгээ .....	52
Хүснэгт 19. ИНБ-ын эрх, эрх чөлөөний байдал, төрлөөр .....	53
Хүснэгт 20. Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулахад учрах саад бэрхшээлийн төрлүүд, зорилтот бүлгээр, хувиар .....	58
Хүснэгт 21. ТББ-ын үйл ажиллагаа нийгэм болон иргэдэд ач тустайг үнэлэхэд нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн нөлөө .....	61
Хүснэгт 22. Төрийн бус байгууллагын нийгэмд үзүүлж буй ач холбогдол, хувиар .....	64
Хүснэгт 23. Судлах зүйл ба нэр томъёо .....	73
Хүснэгт 24. Түүврийн тооцоолол .....	74
Хүснэгт 25. Түүврийн хуваарилалт, хамрах хүрээ .....	75
 Зураг 1. ТББ-ын тайлан хулээн авагчийн төрөл .....	36
Зураг 2. Эрхэзүйн мэдээллийн нэгдсэн системд “төрийн бус байгууллага” үг орсон бичиг баримтуудын агуулга, хувиар .....	38
Зураг 3. Судалгааны аргачлал .....	74
Зураг 4. Чанарын судалгааны хайлтын тулхүүр үг ашигласан загвар схем .....	76
Зураг 5. Тоон судалгаанд ашиглаж буй программ хангамж .....	77
 График 1. Бүртгэлтэй ТББ-уудын тоо .....	11
График 2. ТББ, ААН, Төсвийн байгууллагын эзлэх хувь .....	11
График 3. Байгууллагын үйлчилгээний төрөл, бүртгэлийн төрлөөр, хувиар .....	12
График 4. ТББ-уудын үйл ажиллагааны чиглэл /COPNI 2019 ангиллаар/ .....	14
График 5. Тулгардаг саад бэрхшээл, хувиар .....	17
График 6. Үйл ажиллагаанд тулгамддаг саад бэрхшээл, байршилаар .....	17
График 7. Үйл ажиллагаанд тулгамддаг саад бэрхшээл, байгууллагын төрлөөр .....	18
График 8. Үүсгэн байгуулагч болон гүйцэтгэх алба, хувиар .....	20
График 9. Удирдах зөвлөлийн гишүүдийн тоо .....	21
График 10. Удирдах зөвлөлийн гишүүд, хүйсээр .....	21
График 11. Удирдах зөвлөлийн гишүүдийн насны бутэц, хувиар .....	21
График 12. Удирдах зөвлөлийн хуралдах давтамж, хувиар .....	22
График 13. Батлагдсан дүрэм, журам, хувиар .....	22
График 14. Аудит хийлгэсэн байдал, төрлөөр .....	23
График 15. Гишүүдийн насны бутэц, хувиар .....	23
График 16. Гүйцэтгэх албаны ажилтан, төрлөөр .....	24
График 17. Санхүүгийн ажилтан, төрөл .....	24
График 18. Түр болон гэрээт ажилтан, төрөл .....	24
График 19. Сайн дурын ажилтан, төрлөөр .....	25
График 20. Байгууллагын үйл ажиллагаа улс төр, шашин, эдийн засгийн бүлэглэлээс ангид байж чаддаг эсэх .....	26
График 21. Улс төрийн эрх мэдэлтнийг удирдах зөвлөлд оруулах нь зөв эсэх, хувиар .....	26
График 22. Төсөл, тендерт оролцохын тулд албан бус зардал гаргадаг эсэх, хувиар .....	26
График 23. Байрны төрөл, байршилаар, хувиар .....	27
График 24. Сүүлийн 3 жилийн орлого, зарлага, үндсэн хөрөнгийн дундаж хэмжээ, байршилаар, хувиар .....	28
График 25. Сүүлийн 3 жилийн орлого зарлагын хэмжээ, гишүүнчлэлээр, хувиар .....	29
График 26. Байгууллагын үйл ажиллагааны зардлын төрөл хувиар .....	29
График 27. Сүүлийн 3 жилийн зардлын төрөл, гишүүнчлэлээр, хувиар .....	30
График 28. Орлогын эх үүсвэр, хувиар .....	30
График 29. Санхүүгийн эрсдэлээс хамгаалсан хуримтлалтай эсэх, байршилаар, тоогоор .....	33

График 30. Санхүүгийн эрсдэлээс хамгаалсан хуримтлалтай эсэх, байгууллагын төрлөөр, хувиар .....	33
График 31. 2019 онд төлсөн нийт татварын хэмжээ, байршилаар, төгрөгөөр.....	34
График 32. Сүүлийн 3 жилд санхүүгийн тайлан гаргасан байдал, байршилаар, хувиар .....	36
График 33. Засгийн газрын харьяа байгууллагуудад Х тайлан илгээгээгүй шалтгаан, хувиар .....	37
График 34. Сүүлийн 3 жилд санхүүгийн тайлан гаргасан байдал, хувиар .....	37
График 35. Хамтын ажиллагаанд үүсдэг бэрхшээлүүд, хувиар.....	41
График 36. Хамтын ажиллагаанд учирдаг саад бэрхшээл, үйл ажиллагааны хэлбэрээр .....	41
График 37. Хамтын ажиллагаанд үүсдэг асуудлыг шийдвэрлэх арга зам .....	42
График 38. Арга хэмжээ авдаггүй шалтгаан, байгууллагын төрлөөр, хувиар.....	43
График 39. Арга хэмжээ авдаггүй шалтгаан, байршилаар, хувиар .....	43
График 40. Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа явуулдаг зорилтот бүлэг, хувиар .....	44
График 41. Орон нутаг болон үндэсний хэмжээний бодлогын баримт бичиг, эрх зүйн актад оруулж батлуулсан нэмэлт өөрчлөлтийн тоо, үйл ажиллагааны чиглэлээр .....	45
График 42. ТББ-ын үйл ажиллагаа, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үйл ажиллагааны чиглэлээр .....	46
График 43. Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжилсэн тохиолдол, үйл ажиллагааны чиглэлээр .....	46
График 44. Эрхлэн гүйцэтгэсэн судалгааны тоо, үйл ажиллагааны чиглэлээр .....	46
График 45. Хэвлэн нийтлүүлсэн ном, товхимол, гарын авлагын тоо, үйл ажиллагааны чиглэлээр .....	47
График 46. Байгаль орчны байгууллагын хувьд үйл ажиллагаанд хамрагдсан газар, нутаг, гол горхи, биологийн болон амьтны төрөл зүйл, үйл ажиллагааны чиглэлээр .....	47
График 47. Өөрчлөлт оруулсан бусад үйл ажиллагаа, үйл ажиллагааны чиглэлээр .....	47
График 48. Хууль тогтоомж, бодлого хөтөлбөрт өөрчлөлт оруулсан байдал, байршилаар, хувиар .....	48
График 49. Үйл ажиллагааны чиглэл, бусад .....	48
График 50. Хууль тогтоомж, бодлого хөтөлбөрт өөрчлөлт оруулсан байдал, хувиар .....	49
График 51. Төрийн болон нийтийн үйлчилгээг хэрэгжүүлэх механизмд өөрчлөлт оруулсан байдал, хувиар ....	49
График 52. Төрийн байгууллагын ил тод, хариуцлагатай байдал болон авлигатай тэмцэхэд өөрчлөлт оруулсан эсэх, хувиар .....	50
График 53. Иргэд, олон нийтийн оролцоонд өөрчлөлт гаргасан эсэх, хувиар .....	50
График 54. Хувь хүн, байгаль орчин, амьтан ургамлын зүй зохистой байдалд өөрчлөлт гаргасан эсэх, хувиар .....	50
График 55. Байгууллагын үр нөлөөтэй, бахархдаг сайн жишээ, хувиар .....	51
График 56. Эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, байршилаар, хувиар .....	53
График 57. Мэдээллийн ил тод байдал ба мэдээллийн эрхийн тухай хуулийг ашигладаг эсэх, байршилаар, хувиар .....	54
График 58. Мэдээлэл авч чаддаггүй шалтгаан, байршилаар, тоогоор .....	54
График 59. Мэдээлэл авч чаддаггүй шалтгаан, байгууллагын төрлөөр, хувиар .....	55
График 60. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг шүүмжлэхэд гардаг бэрхшээл, хувиар .....	55
График 61. Интернэтээр үзэл бодлоо илэрхийлэхэд хориг хязгаарлалт байдаг эсэх, хувиар .....	55
График 62. Хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа явуулахад саад бэрхшээл гардаг байдал, үйл ажиллагааны хэлбэрээр, тоогоор .....	56
График 63. Хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа явуулахад саад бэрхшээл гардаг байдал, байршилаар .....	56
График 64. Хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа явуулахад саад бэрхшээл гардаг байдал, зорилтот бүлгээр, тоогоор .....	57
График 65. Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулахад бэрхшээл учирдаг эсэх, хувиар .....	57
График 66. Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулахад учрах саад бэрхшээлийн төрлүүд, байршилаар, хувиар .....	58
График 67. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зарласан эсэх, хувиар .....	59
График 68. Хууль дээдлэх, хүний эрх хамгаалсны төлөө саад бэрхшээлтэй учирсан эсэх, хувиар .....	59
График 69. Хууль дээдлэх ёс, хүний эрх хамгаалсны төлөө учрах саад бэрхшээл, хувиар .....	60
График 70. Төрийн зүгээс үзүүлэх дарамт шахалт, хувиар .....	60
График 71. Хууль шүүхийн байгууллагад хандсан эсэх, хувиар .....	60
График 72. Хууль шүүхийн байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлсэн эсэх, хувиар .....	61
График 73. Иргэдийн хувьд ТББ байгуулдаг шалтгаан .....	62
График 74. Иргэдийн хувьд ТББ байгуулдаг шалтгаан, хүйсээр .....	62
График 75. Иргэдийн хувьд ТББ байгуулдаг шалтгаан, насаар .....	62
График 76. ТББ-ын хийдэг ажил, иргэдийн хувьд .....	63
График 77. ТББ-ын санхүүжилт, оролцогчдын хувьд .....	63
График 78. ТББ нийгэмд тулгамдсан асуудлын талаар төрд нөлөөлж чаддаг эсэх, хувиар .....	63
График 79. ТББ нийгэмд тулгамдсан асуудлын талаар төрд нөлөөлж чаддаг эсэх, хувиар .....	64

**“ИРГЭНИЙ ОРОН ЗАЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН  
ТААТАЙ ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ  
ТОДОРХОЙЛОХ” СУДАЛГААНЫ БАГ**

**Хамтрагч байгууллагууд:**

1. Үндэсний статистикийн хороо
2. “Эс Ай Си Эй” ХХК (SICA LLC)
3. Иргэний нийгмийн Консорциум (үсгийн дарааллаар):
  - Ардчиллын боловсрол төв (ДЕМО)
  - Ахиллис Монгол
  - “Бүх нийт боловсролын төлөө!” үндэсний эвсэл
  - МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ
  - Монголын эмнести интернэшнл
  - Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо
  - Нээлттэй нийгэм форум
  - Транспаренси Интернэшнл Монгол
  - Хүний эрх, хөгжил төв
  - Ц.Батсугар, Иргэний нийгмийн судлаач
  - Б.Болорсайхан, Хүний эрхийн шинжээч
  - Д.Сүхжаргалмаа, Жендэр шинжээч

**Судалгааны багийн зөвлөх**

Г.Ундрал, Ардчиллын боловсрол төв (ДЕМО)-ийн захирал

**Тайлланг бичсэн**

О.Саранчулуун

Судлаач, АШУҮИС-ын НЭМС-ийн багш, Ахиллис Монгол ТББ-ын тэргүүн

Ц.Батсугар

Судлаач, багийн гишүүн

**Тоон судалгааны зөвлөх**

Г.Эрдэнэ

Эдийн засгийн магистр, “Эс Ай Си Эй” ХХК-ийн Дэд захирал

**Тоон судалгааны баг**

С.Дарханхишиг

Эдийн засгийн магистр, “Эс Ай Си Эй” ХХК-ийн Судалгааны газрын менежер

Т.Түмэнчимэг

Эдийн засгийн бакалавр, “Эс Ай Си Эй” ХХК-ийн Судалгааны газрын ахлах менежер

Э.Нямдаваа

Программ хангамжийн бакалавр, “Эс Ай Си Эй” ХХК-ийн Мэдээлэл цуглувалт, боловсруулалтын хэлтсийн ахлах менежер

Б.Төрцэцэг

Герман хэл судлалын бакалавр, “Эс Ай Си Эй” ХХК-ийн Мэдээлэл цуглувалт, боловсруулалтын хэлтсийн хянаагч судлаач



## ТОВЧИЛСОН УГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААНБОАТ	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
АТБХЭ	Ашгийн төлөө бус хуулийн этгээд
АТБХЭтХ	Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хууль
ГҮТББ	Гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗБН	Заавал байлгах нөөц
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МОНГОЛ УЛС	Монгол Улс
МОНГОЛ УЛСЗН	Монголын улаан загалмайн нийгэмлэг
МОХ	Монголын үндэсний Олимпийн Хороо
МХАЙТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ОУ	Олон Улс
ОУБ	Олон улсын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТБМНС	Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УЗ	Удирдах зөвлөл
УИХ	Улсын их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮЭБ	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЭУБтХ	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
ЭЗҮАСА	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал
COPNI	Classification of the Purposes of Non-Profit Institutions

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Монгол Улсад Төрийн бус байгууллага (ТББ)-ын тухай хууль 1997 онд батлагдсанаас хойш иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, хүний эрхийг хангахад ТББ-үуд үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэж ирсэн. Хууль батлагдсанаас хойш үйл ажиллагаа явуулах ТББ-үүдүүн тоо өсөж, зохион байгуулалт, үйл ажиллагаа, салбар чиглэл, нийслэл, аймаг бүрд хүрч ажилладаг иргэний нийгэм төлөвшин хөгжиж байна.

ТББ-ын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, иргэний нийгмийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлэхийн тулд иргэний нийгмийн төлөөлөл бүхий Консорциум 2019 оны 6-р сараас 2020 оны 6-р сарын хооронд “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хууль” (АТБХЭТХ)-ийн төслийг иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-аар хэлэлцэх, “МОНГОЛ УЛС-ын төр, иргэний нийгмийн түншлэлийн үзэл баримтлал (бодлого)”-ыг төслийг шинэчлэх, АТБХЭТХ-ийн төслийг бовсруулж нөлөөлөл хийхээр ажиллаж байна.

Үүний тулд иргэний нийгмийн салбар, ТББ-ын олон янз байдал, төрөл, хэлбэр, тэдгээрийн онцлог болон тулгамдаж буй асуудлыг бодитоор тодорхойлох, салбарын суурь нөхцөл байдлыг тодруулах зайлшгүй шаардлага үүсэж байгаа тул иргэний нийгмийн төлөөлөл бүхий Иргэний нийгмийн Консорциумаас “Иргэний орон зайн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчныг бий болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох” судалгааг санаачилж, улмаар Нээлттэй нийгэм форум болон “Форум Ази” бүсийн байгууллагын дэмжлэгтэйгээр энэхүү судалгааг гүйцэтгэв.

Энэ судалгаа нь ТББ-ын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайжруулахтай холбоотой нөлөөллийн үйл ажиллагааг баримт, дүн шинжилгээ бүхий мэдээллээр хангах үндсэн зорилгоос гадна ИНБ-ын үйл ажиллагаа болон оролцогч талуудын зураглалыг тодорхойлох, ИНБ-ын үйл ажиллагааны үр нөлөө болон Монгол Улс дахь иргэний орон зайн өнөөгийн төлөв байдлыг судлах зорилтуудыг агуулсан болно.

Судалгаанд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ-үүдүүн төлөөлөл болох 683 байгууллагаас тоон мэдээлэл цуглуулж, ТББ, төр, гадаад болон олон улс (ОУ)-ын байгууллага, хэвлэл мэдээлэл зэрэг оролцогч талуудтай бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийж чанарын мэдээллээр баяжуулав. Мөн иргэний нийгмийн салбарт өмнө хийгдсэн судалгаа, хууль эрх зүй болон бодлогын баримт бичигт шинжилгээ хийж, олон талын байр суурь, мэдээллийг нэгтгэхийг зорив.

Иргэний нийгэм, ардчилал, ТББ-ын үйл ажиллагааны талаар сэдэвчилсэн судалгаа хийгдэж байсан хэдий ч иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, ИНБ-ын үйл ажиллагаа, хамтын ажиллагаа, үр нөлөө зэрэг төлөв байдлыг улсын хэмжээнд тусгайлан судалсан судалгаа одоогоор хийгдээгүй байна. Энэхүү судалгаа нь энэ орон зайнг нөхөж, ТББ-ын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогыг тодорхойлоход баримт нотолгоо болж, мэдээллээр хангах суурь баримт бичиг болно гэдэгт итгэлтэй байна.

Иргэний нийгмийн Консорциум

## БҮЛЭГ 1. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛ, ЧИГЛЭЛ

### 1.1. ТББ-ЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР

#### 1.1.1. ТББ-ЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Иргэний нийгмийн салбар, тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хуулийн этгээд, тэдгээрийн онцлог мөн чанартай холбоотой ялгаатай ойлголтуудыг практик болон эрх зүйн орчинд хэрэглэсээр иржээ. Тухайлбал, 1997 оны ТББ-ын тухай хуульд ТББ гэх ойлголтыг өргөн хүрээнд хэрэглэж ирсэн бол Иргэний хуульд *ашигийн төлөө* бус гэж хуулийн этгээдийн зорилгоор нь ангилан ирсэн. Түүнчлэн, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссийн тухай хууль, Хөгжлийн Бодлого, Төлөвлөлт, Түүний Удирдлагын тухай хууль зэрэг хуульд иргэний нийгэм гэх ойлголтыг хэрэглэсээр байна. Түүнчлэн, ОУБ-уудын практик хэрэглээг даган ИНБ гэх ойлголт ч мөн ашиглагдсаар байна. Тухайлбал, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд залуучуудын ИНБ гэх ойлголтыг ашигласан байдаг.

*Төрийн бус байгууллага гэдэг уг хууль зүйн мэдээллийн нэгдсэн санд хүчинтэй байгаа 55 хууль, 27 тогтоол, тушаал, журмын баримт бичигт орсон байна (Эрхзүйн мэдээллийн нэгдсэн сан, 2020).*

#### Хүснэгт 1. ТББ-ЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хуулийн нэр	ТББ-ЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	Ангилал
Төрийн тус байгууллагын тухай хууль (УИХ, 1997)	<p>...нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллага хамаарна.</p> <p>...иргэд, төрийн байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага)-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ.</p>	<p>Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага</p> <p>Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага</p>
Иргэний хууль	<p>...Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.</p> <p>...Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ..</p> <p>...Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ.</p> <p>...Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.</p> <p>...Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаарх хуулийн заалтыг мөрдөнө</p>	<p>Холбоо Сан Хоршоо</p>
Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны	“Сууц өмчлөгчдийн холбоо” гэж нийтийн зориулалттай орон сууцны байшин (цаашид “орон сууцны байшин” гэх)-гийн дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, тухайн орон сууцны байшингийн ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн	Холбоо

байшигийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай	эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг эрхлэн хариуцах зорилго бүхий, хуулийн этгээдийн эрхгүй, заавал гишүүнчлэлтэй холбоо	
Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгч	ТББ, сан, шашны байгууллага, хоршоо
Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө	Төрийн бус байгууллага

Ийнхүү ялгаатай ойлголтуудыг хэрэглэснээр ТББ-ын төрөл хэлбэрийн зохицуулалт нь эрх зүйн зөрчилтэй байдлыг үүсгэж байна. Тухайлбал:

- 2002 онд шинэчлэн батлагдсан Иргэний хуулиар “ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэрүүдийг “холбоо, сан, хоршоо” гэж нэрлэсэн ч тус хуулийн 36.6-д “сүм хийд” нь иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаарх хуулийн заалтыг мөрдөнө гэж зохицуулсан. Улмаар Иргэний хуулийн 36.3 болон 36.5-д “Холбоо, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно”, “хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна” гэж тус тус заасан. Гэвч холбоо, сангийн эрх зүйн байдлыг тогтоосон хууль одоогоор байхгүй бөгөөд ТББ-ын тухай хуулиар зохицуулагдаж байна.
- ТББ-ын талаарх ойлголтыг 1997 оны Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулсан ба “холбоо” гэсэн нэр томьёо одоог хүртэл тус хуульд байхгүй, харин “сан” гэх нэр томьёо 2002 онд Иргэний хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор орсон.
- Иргэний хуулийг дагаж мөрдөхтэй холбоотойгоор Иргэний хуульд өмнө нь батлагдсан байсан “ТББ-ын тухай хууль”-ийг нийцүүлэхдээ: “Сантай холбоотой тусгай зохицуулалт” гэх 7-р бүлгийг “ТББ-ын тухай хууль”-д шинээр нэмснээр Иргэний хуулийн “сан” гэсэн бие даасан хэлбэр нь ТББ гэх Иргэний хуульд байхгүй хэлбэрийн дотор багтах гажуудлыг бий болгосон. Үүний үр дагаварт Хуульч эмэгтэйчүүдийн холбоо гэж бүртгэлтэй байгууллага нь Хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ, Залуу удирдагч Сан байсан нь Залуу удирдагч сан ТББ гэх болсон. (ТББ-ын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, 2017)
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (ХЭУБтХ, 2015)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “хуулийн этгээд гэж Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан шинжийг агуулсан зохион байгуулалтын нэгдлийг ойлгоно” хэмээн заасан атал, 8 дугаар зүйлд 12 төрлийн хуулийн этгээдийн хэлбэрийг улсын бүртгэлд бүртгэхээр тогтоосон нь Иргэний хуулийн 33 дугаар зүйлд тодорхойлсон хуулийн этгээдийн 5 хэлбэрээс зөрүүтэй байгаа юм. (Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, 2018)

Иргэний хууль ба Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар ашгийн бус хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тус бүр ялгаатай тодорхойлсноос гадна Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас энэ төрөл, хэлбэрийн тоог практикт хоёр дахин нэмэгдүүлсэн байгааг судлаачид тогтоожээ. (Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн

зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага, 2018) Төрөөр хэлбэл, дээрх эрх зүйн зохицуулалтад байхгүй төрлийн ТББ-ыг бүртгэх практик байсан гэсэн үг юм.

Эрхзүйн ангилал, хуулийн этгээдийн тодорхойгүй байдлын талаарх бүлгийн ярилцлагад оролцогчдын санал бодлыг тоймловол сайжруулах шаардлагатайг хэд хэдэн үндэслэлээр дурдаж байв. Үүнд:

- Өнөөгийн бүртгэлийн эмх цэгцгүй байдал нь ТББ нь зорилгоосоо хазайсан, хийсвэр олон тооны ТББ-ыг бий болгож байна.
- ТББ-ын өмчийн хэлбэрийн мэдээлэл бүрхэг байна. Бүртгэлийг хийж буй УБЕГ нь тэр өмчийн эх үүсвэрийн мэдээлэлгүй, банк дээр жинхэнэ эзэмшигч нь биш, Гүйцэтгэх захирал байдаг нь ил тод бус байдлыг үүсгэдэг. Хөрөнгийн эх үүсвэрийг бүртгэдэггүй учраас маргаан гардаг.

Харин ТББ-уудын төлөөлөл нь 1997 оны ТББ-ын тухай хуулиар төрөл, хэлбэрийг өргөн агуулгаар тодорхойлж өгсөн нь ТББ-ууд өөрт тохирсон хэлбэр, бүтэц зохион байгуулалт, засаглалын тогтолцоог хэрэгжүүлэн, бие даан хөгжих боломжийг олгосон гэж үзэж байна. Мөн тэд ТББ-ын эрх зүйн зохицуулалтыг сайжруулахдаа ашгийн бус хуулийн этгээдийн төрлийг хэт явцууруулан тодорхойлж, түүний зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо зэргийг хатуу хуульчлах нь иргэний нийгэм, ашгийн бус салбар цаашид хөгжихэд хязгаарлалт болно гэсэн байр суурийг илэрхийлж байна. Ийм төрлийн хязгаарлалт, бэрхшээл одоо ч зарим онцлог зохион байгуулалт бүхий ТББ-уудад тулгарч байгааг тэд хэлж байв. Харин 1997 оны ТББ-ын тухай хууль нь ТББ-ын эрх үүрэг, харилцаа, төрөл зэргийг хэт нарийвчлан тусгаагүй нь ТББ-ууд нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлага, ОУ-ын туршлагад суурилан чөлөөтэй хөгжих хөрсийг бий болгосон давуу талтай гэж дүгнэж байна.

#### Шигтгээ 1

...Байгууллагыг хуульд зааснаар сан, төв, холбоо гэх мэт хэлбэрээр хэрхэвч зааеварчилж болохгүй. Манай байгууллага хяналтын үүрэг гүйцэтгэж эхэлсэн, цаашлаад судалгаа, шүүхийн бус гомдлын механизмд оролцод явж байна. Тэгэхээр байгууллагын хөгжил чөлөөтэй байх ёстой болохоор манай байгууллагыг ямар ч тохиолдолд төв, сан, холбоо гэж нэрлэх боломж байхгүй. - ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ФБЯ-ын оролцогч Б.


ТББ-ууд зохион байгуулалтын хэлбэр, түүнтэй уялдсан дотоод засаглалын тогтолцоо, үйл ажиллагааны салбар, чиглэл харилцан адилгүй, олон янз хэлбэртэй байдгийг судалгаанд оролцсон байгууллагууд болон бусад практик туршлага, судалгаа, тоон мэдээллээс төвөггүй харж болно.

ТББ-ын тухай хуулийг шинэчлэн найруулах өмнөх хэд хэдэн оролдлогуудад хуулийн этгээдийн хэлбэртэй холбоотой дээрх зөрчлийг арилгаж, “холбоо”, “сан” гэсэн хэлбэрүүдийг хуульчлахаар зорьсон ч эдгээр нь иргэний нийгмийн өнөөгийн олон янз байдлыг бүрэн илэрхийлж чадахгүй байгааг ТББ-уудын төлөөлөл анхааруулсаар байна. (АТБХЭТХ-ийн төсөлд хийсэн дүн шинжилгээний тайлан, 2019)

### 1.1.2. ТББ-ын хэлбэр, тэдгээрийн тоо хэмжээ


Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 24,276 бүртгэлтэй ТББ байгаагаас үйл ажиллагаа явуулж байгаа нь 10,806 байна. (Үндэсний статистикийн хороо, Бизнес регистрийн сан, 2020)

*График 1. Бүртгэлтэй ТББ-ын тоо*



2013 оноос бүртгэлтэй ТББ болон үйл ажиллагаа эрхлээгүй ТББ-ын тоо хурдтай нэмэгдэх болсон байна. Нийт бүртгэлтэй ААНБ-ын дунд эзэлж буй ТББ-ын хувь хэмжээ 1998 онд 5.7% байснаас 2020 онд 9.7% болж 2 дахин нэмэгдсэн байна (Үндэсний статистикийн хороо , 2020).

*График 2. ТББ, ААН, Төсвийн байгууллагын эзлэх хуеъ*



2020 оны 4 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын 59.9% нь нийслэлд үйл ажиллагаа явуулж байна. (Үндэсний статистикийн хороо, Бизнес регистрийн

сан, 2020) Улаанбаатарын дараагаар Дархан-Уул, Орхон, Дорнод, Ховд аймгуудад хамгийн олон ТББ бүртгэлтэй байна.

Харин УБЕГ-ын мэдээлэлд 2019 оны байдлаар 22,074 ТББ, 1,598 сан, 1,453 үйлдвэрчний эвлэл, 543 шашны байгууллага, 585 боловсрол, сургалтын байгууллага, 1,062 хэвлэл мэдээллийн байгууллага бүртгэлтэй байна. (УБЕГ, 2020)


- Нэгд, УБЕГ болон ҮСХ-ны ТББ-ын тоон мэдээ зөрүүтэй байна. УБЕГ нь ТББ болон холбоог нэг ангиллаар бүртгэж байна.
  - Түүнчлэн, боловсрол, сургалтын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг Иргэний хуульд байхгүй төрөл, хэлбэрээр бүртгэл хийгдсээр байна. Мөн эдгээр төрлийн байгууллагууд нь дотроо ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байж болох ч, хэлбэрийн хувьд компаний ч, ТББ-ын ч төрөлд багтахгүй байгаа юм.

УБЕГ-т хуулийн этгээдийн бүртгэлийг хийхдээ 2018 оны УБЕГ-ын даргын А/420 тушаалтын дагуу холбоо (үүнд: НҮТББ, ГҮТББ, үйлдвэрчний эвлэлийн холбоо), нийтийн эрхзүйн хуулийн этгээд, үндэсний хүмүүнлэгийн байгууллага, холбоо (боловсрол сургалтын байгууллага), сан, улс төрийн нам, холбоо (хэвлэл мэдээллийн байгууллага: сонин, сэтгүүл, радио, телевиз) зэрэг нийт 10 төрлөөр бүртгэж индексжүүлж байна (УБЕГ, 2020). Үүнээс үзвэл, одоогоор бүртгэлтэй бүх ТББ, боловсрол, сургалтын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд нь холбоо гэсэн хэлбэрээр бүртгэгдэж байна.

УБЕГ-ын дээрх бүртгэлийн индексийг харвал 22,074 ТББ нь НҮТББ болон ГҮТББ аль алиныг нь багтаасан тоо байна. Хэдий тийм ч УБЕГ-ын статистик нь энэхүү хоёр төрлөөр ялгаатай гардаггүй учир хамгийн суулийн статистик мэдээлэл байхгүй байна. Ямартай ч 2018 оны 6 дугаар сарын байдлаар нийт 17,634 ИНБ Улсын бүртгэлийн өрөнхий газар албан ёсоор бүртгэлтэй байгаагаас “нийгэмд үйлчилдэг” 15,241, “гишүүддээ үйлчилдэг” 2,393 ТББ байна. Өөрөөр хэлбэл, бүртгэлтэй ТББ-уудын 86.4% нь НҮТББ байжээ.(УБЕГ-ийн албан мэдээллээс, 2020)

Судалгаанд оролцогч байгууллагуудын 17.9% нь гишүүдэд үйлчилдэг, 55.6% нь зөвхөн нийгэмд үйлчилдэг, харин 26.5% нь гишүүдэд болон нийгэмд үйлчилдэг гэж өөрсдийн зорилгыг тодорхойлж байна. Энэ нь УБЕГ-ын статистик мэдээлэлтэй ижил үр дүн юм.

*График 3. Байгууллагын үйлчилгээний төрөл, бүртгэлийн төрлөөр, хувцас*



Гишүүдэд үйлчлэх зорилго бүхий сан, зөвхөн нийгэмд үйлчилдэг холбоо байгаа нь нэг талаас бүртгэлийн тогтолцоог сайжруулах шаардлага байгааг, нөгөө талаас ТББ-ын төрөл, хэлбэрийн хууль, журмын ангилал нь тухайн байгууллагын үүсгэн байгуулагдсан зорилгыг бүрэн дүүрэн илэрхийлэхгүй байгааг харуулж байна. Тухайлбал, Хуулийн

этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль 2018 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэнээр түүнээс өмнө бүртгэгдсэн ТББ-уудыг холбооны ангилалд бүртгэсэн нь гишүүнчлэлгүй ТББ-уудыг холбооны ангиллаар бүртгэсэн байна. Судалгааны дүнгээр ТББ, Холбооны хэлбэрээр бүртгэгдсэн байгууллагуудын 36.0% нь хувь хүмүүсийн гишүүнчлэлтэй, харин 16.8% нь ААНБ-ын гишүүнчлэлтэй бол үлдсэн 47.2% нь ямар нэг гишүүнчлэлгүй байна. Харин эсрэгээрээ судалгаанд оролцсон 18 сангийн 9 нь хувь хүн эсвэл ААНБ-ын гишүүнчлэлтэй байна.

Бүртгэлийн байгууллага, тэдгээрийн албан хаагчдын хууль эрх зүйн ойлголт, мэдлэг дутмаг, хууль эрх зүйн зохицуулалтыг нарийн үндэслэхээс илүүтэй хэрэглэгдэж ирсэн практик туршлагад үндэслэн бүртгэлийг гүйцэтгэдэг талаар ФБЯ-ын үеэр ТББ-ын төлөөлөл хөндөж байв.

Хэдий тийм ч судалгааны дүнгээс ч, УБЕГ-ын статистик мэдээллээс ч ТББ-ууд нь нийгэмд үйлчлэх зорилгоор буюу нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахаар зохион байгуулагдаж байгаа **нийгмийн капитал мөн** гэдэг нь тодорхой харагдаж байна.

## 1.2. ТББ-ын үйл ажиллагааны салбар, чиглэл

Иргэний нийгмийн салбарын дүр төрхийг бүрэн тодорхойлохын тулд ТББ-ын үйл ажиллагааны салбар, чиглэлийн зураглалыг оновчтой тодорхойлох ёстой. Энэ нь дараах ач холбогдолтой:

- ТББ-ын хэлбэрээр ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа явуулж татвараас зайлсхийх хандлага байгаа талаар шүүмж гардаг. Тухайлбал, боловсрол сургалтын байгууллага, эмнэлэг, хэвлэл мэдээллийн байгууллага нь татвараас зайлсхийх зорилгоор ТББ-ын хэлбэрээр бүртгүүлж, үйл ажиллагаа явуулж байна гэх шүүмж ихээхэн байдаг.
- Нийгэмд тустай үйл ажиллагааны салбар, чиглэл, төрөл хэлбэрийг тогтооход ТББ-ын өнөөгийн үйл ажиллагааны зураглал ихээхэн ач холбогдолтой юм. Нийтэд тустай үйл ажиллагааг зүй зохистой тодорхойлсноор түүнтэй уялдан зохицуулагдах татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон бусад зохицуулалтын арга хэмжээ илүү үр дүнтэй, бодит байдалд нийцсэн болох юм.
- Эцэст нь, ТББ-ын үйл ажиллагааны хүрээнд хөндөгддөг нэг асуудал нь аж ахуйн үйл ажиллагаа юм. Өнөөгийн түвшинд ТББ нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй түвшин, цаашид эрхлэх чадавх, нөөц зэргийг бүрэн тодорхойлсноор аж ахуйн үйл ажиллагааны зохицуулалт нь ТББ-ын тогтвортой хөгжилд ямар үр нөлөө үзүүлэхийг зөв тооцох ёстой юм.

Харамсалтай нь, ТББ-ын үйл ажиллагааны зураглалыг дээрх зорилгоор бүрэн дүүрэн гаргах мэдээллийн эх сурвалж, өгөгдөл өнөөг хүртэл хязгаарлагдмал байсаар байна.

ҮСХ-ны Бизнес регистрийн сангаас Эдийн Засгийн Үйл Ажиллагааны Салбарын Ангиллын (ЭЗҮАСА) дагуу ТББ-ын үйл ажиллагааг ангилан бүртгэдэг.

### Хүснэгт 2. ТББ-ын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

№	Салбар	2020-IV
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	125
2	Уул уурхай, олборлолт	0
3	Боловсруулах үйлдвэрлэл	8
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0
5	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл	0

	ажиллагаа	
<b>6</b>	Барилга	0
<b>7</b>	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	0
<b>8</b>	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0
<b>9</b>	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	0
<b>10</b>	Мэдээлэл, холбоо	114
<b>11</b>	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1
<b>12</b>	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4
<b>13</b>	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	202
<b>14</b>	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	71
<b>15</b>	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0
<b>16</b>	Боловсрол	1,089
<b>17</b>	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	202
<b>18</b>	Урлаг, үзвэр, тоглоом наадам	463
<b>19</b>	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	8,249

Дээрх ангиллаар авч үзэхэд ТББ-ын 80 гаруй хувь нь Үйлчилгээний бусад үйл ажиллагаа гэсэн ангилалд хамаарч байна.

Энэ ангилалд:

- Гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаа,
- Компьютер, ахуйн бараа, хувийн хэрэглээний зориулалттай бараа эд зүйлсийн засвар, үйлчилгээ,
- Хувийн үйлчилгээний бусад үйл ажиллагаа гэсэн дэд ангиллууд багтаж байна.


Үүнээс ТББ-үүд нь эхний ангиллын хүрээнд бүртгэгдсэн байна. Хэдий тийм ч 80 гаруй хувь нь гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаанд хамрагдаж байгаа нь бодит байдалтай бүрэн дүүрэн нийцэхгүй юм. Учир нь судалгааны дүнгээр нийт ТББ-ын 56.1% нь л гишүүнчлэлтэй юм.

Дараагийн хамгийн түгээмэл ЭЗҮАСА нь Боловсрол байна. Боловсролын салбарт нийт ТББ-ын 10.3% нь үйл ажиллагаа явуулж байна. (ҮСХ, Бизнес регистрийн сан, 2020) Тоогоор нь авч үзвэл хамгийн түгээмэл үйл ажиллагааны салбар нь:

- Гишүүнчлэл бүхий бусад байгууллагын үйл ажиллагаа – 6,590 ТББ
- Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа – 1,089 ТББ
- Бага, бүрэн дунд, дээд боловсролоос бусад боловсрол олгох үйл ажиллагаа – 874 ТББ
- Бизнес, ажил олгогч болон мэргэжлийн гишүүнчлэл бүхий үйл ажиллагаа – 550 ТББ
- Спортын үйл ажиллагаа – 362 ТББ тус тус байна.

ТББ-ын үйл ажиллагааны өөр нэг ангиллын хэлбэр нь НҮБ-ын Өрхөд Үйлчлэх Ашгийн бус Байгууллагын Зорилгын Ангилал (COPNI) юм. Манай судалгааны хүрээнд уг ангиллыг ашиглан ТББ-ын үйл ажиллагааг зураглахыг оролдов.

*График 4. ТББ-ын үйл ажиллагааны чиглэл /COPNI 2019 ангиллаар/*



Энэхүү ангиллаар мөн л “Дээрх ангилалд ороогүй бусад үйл ажиллагаа” эрхлэгч ТББ 25.5% байгаа нь дээрх хоёр ангилал нь ТББ-ын үйл ажиллагааны олон янз байдлыг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй байгааг харуулж байна.

Гэвч ЭЗҮАСА-аас ялгаатай нь уг ангиллаар бид ТББ-ын үйл ажиллагаа эрхэлж буй салбарыг харьцангуй байдлаар тодорхойлох боломжтой байна. Судалгааны дүнгээр хамгийн түгээмэл үйл ажиллагааны салбар нь “Боловсролын бусад үйлчилгээ” байгаа нь Бизнес регистрийн сангийн статистиктай тохирч байна. Үүнээс гадна нийгмийн хамгааллын үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, шашин, соёлын үйл ажиллагаа зэрэг чиглэлд ТББ-үүд түгээмэл үйл ажиллагаа явуулж байгаа нь Бизнес регистрийн сангаас ялгаатай дүн юм.

Гэсэн хэдий ч судалгааны дүн, Бизнес регистрийн сангийн дүнгээр бүх шатны сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага нь маш цөөн байгаа нь энэ чиглэлийн байгууллагууд татвараас зайлсхийх зорилгоор ТББ-ын хэлбэрээр үйл

ажиллагаа эрхэлдэг гэсэн түгээмэл шүүмжлэлтэй нийцэхгүй байна. Хэдий ийм тохиолдлууд байж болох ч энэ нь ТББ-ын нийтлэг дүр төрх биш юм.

Дээрх салбар чиглэлд үйл ажиллагаа явуулахдаа ТББ дараах үйл ажиллагааны хэлбэрүүдийг ашигладаг байна.

#### **Хүснэгт 3. Байгууллагын үйл ажиллагааны хэлбэр, засаг захиргааны түвшнээр**

№	Үйл ажиллагааны хэлбэр	Олон улсын	Үндэсний	Аймаг, нийслэлийн	Сум, дүүргийн	Хороо, багийн	Бусад
1	Сургалт	81.1%	73.4%	75.6%	55.8%	26.5%	50.0%
2	Судалгаа	45.3%	53.6%	47.0%	20.4%	8.8%	37.5%
3	Зөвлөгөө	47.2%	60.9%	57.2%	41.6%	20.6%	50.0%
4	Нэлөөлөл	28.3%	41.7%	41.7%	38.1%	23.5%	50.0%
5	Өмгөөлөл	3.8%	7.8%	13.1%	8.0%	2.9%	25.0%
6	Тусlamж үйлчилгээ	28.3%	26.0%	47.7%	40.7%	73.5%	75.0%
7	Мэдээллийн үйлчилгээ	58.5%	55.7%	38.5%	30.1%	35.3%	62.5%
8	Сурталчилгаа	18.9%	29.7%	24.4%	18.6%	2.9%	50.0%
9	Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний мониторинг	9.4%	12.5%	7.8%	7.1%	-	12.5%
10	Улсын болон орон нутгийн төсвийн хяналт	1.9%	4.7%	4.6%	1.8%	-	-
11	Бусад	1.9%	-	1.8%	0.9%	-	-

Үндэсний болон аймаг нийслэлийн түвшинд үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нь сургалт, судалгаа, зөвлөгөө, нэлөөлөл, мэдээллийн үйл ажиллагаа түлхүү хэрэгжүүлж байна. Баг, хороо, сум дүүргийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд нь ихэвчлэн тусlamж үйлчилгээ, сургалт, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ явуулж байна. Харин төрийн үйлчилгээний мониторинг, төсвийн хяналт, өмгөөлөл, сурталчилгаа зэрэг чиглэлийн үйл ажиллаагаа эрхэлдэг ТББ аль ч түвшинд маш цөн байна. Түүнчлэн аж ахуйн үйл ажиллагааны хувьд судалгаанд оролцсон ТББ-уудын 30.7% нь л аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсэн байна. Үүнд:

- ОУ-ын, үндэсний, болон аймаг, нийслэлийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх нь сум, дүүрэг, баг, хорооны түвшинд үйл ажиллагаа явуулж буй ТББ-аас 2 дахин их байна. Үндсэндээ, ТББ-ын үйл ажиллагааны явуулж буй түвшин ахих тусам аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх нь нэмэгдэж байна. Энэ нь орон нутгийн (grassroot) ТББ-ууд нь чадавх, нөөцийн хувьд сүл байдагтай холбоотой байж болох юм.
- Нийгэмд үйлчилдэг ТББ-ууд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх нь илүү байна. Тухайлбал, НҮТББ-ын 38.2%, Нийгэмд болон гишүүдэд үйлчилдэг ТББ-ын 25.4%, ГҮТББ-ын 15.6% нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэж, орлого олсон байна.
- Үйл ажиллагааны салбараар нь авч үзвэл соёлын үйл ажиллагаа эрхлэгчдийн 52.6%, боловсролын бусад үйлчилгээ эрхлэгчдийн 43.4% нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсэн байдлаар тэргүүлж байна.

Харамсалтай нь эдгээр аж ахуйн үйл ажиллагаа нь чухам ямар төрлийн үйл ажиллагаа болох, орлогын хэдий хувийг аж ахуйн үйл ажиллагааны орлого эзэлж буйг тодорхойлох мэдээлэл хангалтгүй байна.

ФБЯ-д оролцсон зарим байгууллага нь мерчандайз хийх байдлаар аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй жишээ гарч байв.


### 1.2.1. Үйл ажиллагаанд тулгамддаг саад бэрхшээл

Судалгаанд оролцсон ТББ-уудын 93.6% нь анх бүртгүүлсэн төрлөөрөө буюу үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөөгүй байна.

Харин судалгаанд оролцсон ТББ-уудын 18.0%-ийнх нь үйл ажиллагаа нь тасалдаж байжээ. Тэдний 77.2% нь 1-2 удаа үйл ажиллагаа нь тасалдсан бол үлдсэн 22.8% нь 3 ба түүнээс олон удаа тасалдаж байжээ. ТББ-ын үйл ажиллагаа нь тасалдахдаа ихэвчлэн буюу 91.9%-д нь 3 сараас дээш хугацаагаар тасалдаж, 67.5%-д нь санхүүжилтийн асуудлаас, 35.0%-д нь бусад асуудлаас болж тасалдсан байна.

Үүнээс үзэхэд ТББ-ын үйл ажиллагаанд санхүүгийн асуудал, ажиллах хүчний хомсдол болон бусад асуудлаас болж хүндрэл бэрхшээл тулгарч байна. Энэ нь ТББ-ын үйл ажиллагаанд хамгийн их тулгардаг саад бэрхшээл нь санхүүгийн дэмжлэг дутмаг байдал бол удаах нь төрийн дэмжлэг хангалтгүй, төрийн хүнд суртал мөн шударга бус байдал гэснээс харагдаж байна.

График 5. Тулгардаг саад бэрхшээл, хувиар




Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хувьд санхүүгийн дэмжлэг дутмаг, ТББ-ын чадавх, иргэдийн оролцоо сул зэрэг саад бэрхшээл байна. Харин төрийн дэмжлэг хангалтгүй, төрийн хүнд суртал, авлига, шударга бус байдлын талаарх бэрхшээл нь Улаанбаатар хотод түлхүү тулгардаг гэсэн үзүүлэлттэй байна.

График 6. Үйл ажиллагаанд тулгамддаг саад бэрхшээл, байршилаар



Түүнчлэн санхүүгийн дэмжлэг дутмаг, төрийн дэмжлэг хангалтгүй зэрэг бэрхшээл нь голдуу нийгэм, нийгэм болон гишүүддээ үйлчилдэг байгууллагууд илүү тулгамддаг байна.

**График 7. Үйл ажиллагаанд тулгамддаг саад бэрхшээл, байгууллагын төрлөөр**



Өмнө хийгдсэн ижил төстэй судалгаануудад ТББ-ын үйл ажиллагаа тасалдах хэд хэдэн шалтгааныг тайлбарлаж байжээ. Үүнд:

- Тэдний нөөц их боловч, чадваржуулах, мэдлэгжүүлэх арга зүйн туслалцаа байхгүй, Завхан аймаг, ТББ, Фокус группийн ярилцлага (Зохиостой Хөгжлийн Жендэр Төв, 2005)
- Том жижиг янз бурийн татварын асуудлууд ("Баасанжав консалтинг" ХХК, 2017)
- Олон давхар хязгаарлалт үе шат бүхий шалгуур бүхий дэмжлэг зэргийг нэрлэжээ ("Баасанжав консалтинг" ХХК, 2017)
- Түүнчлэн ТББ-уудад хандивлагч иргэн, ААН, байгууллагад үзүүлэх урамшуулал буюу татвар, хураамжийн хөнгөлөлтийн бодлого байхгүй нь дотоодын дэмжигчдийн хүрээг буруулж, улмаар нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, нийгмийн төлөөх үйл ажиллагааны дэмжлэг тасралтгүй байх нөхцөлийг алдагдуулж байна. ("Баасанжав консалтинг" ХХК, 2017)

Эдгээрээс гадна ТББ-ын чадавх, хүний нөөцийн асуудал чухал нөлөөтэй байна. Тухайлбал, 2016 онд хийгдсэн Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх төслийн суурь судалгаагаар ТББ-уудын дийлэнхи нь чадавхийн хувьд бэхжээгүй, сул байна. ТББ-ын 35.0% нь зөвхөн 1, 31.0% нь 2-3, харин 7.0% нь л 10 болон түүнээс дээш тооны орон тооны буюу бүтэн цагийн ажилтантай. (Baseline survey of Mainstreaming Social Accountability in Mongolia project, IRIM, 2016) Түүнчлэн, YCH-ны Бизнес регистрийн сангийн дүнгээр үйл ажиллагаа явуулж буй 10,806 ТББ-ын 90.4% нь 1-9 ажилтантай байна.

Үйл ажиллагаа тасалдаад нөлөөлөхөөс гадна үйл ажиллагаа эрхлэхэд тодорхой бэрхшээл, хүндрэл гарч байгааг фокус бүлгийн ярилцлагад оролцогчид илэрхийлж байв. Үүнд:

- ТББ-д үйл ажиллагаа явуулахад зарим салбар чиглэлд тусгай зөвшөөрөл шаардлагатай болдог байна. ТББ-ын зохицуулалтын ойлгомжгүй байдлаас тусгай зөвшөөрөл авахын тулд бүртгэлээ шинэчлүүлэх, тусдаа бие даасан ТББ дахин шинээр байгуулах зэрэг төвөг чирэгдэл гарч байна. Тухайлбал, боловсрол, сургалт, цэцэрлэг, хүүхэд хамгаалал зэрэг тодорхой чиглэлийн үйл ажиллагаа явуулахад ТББ-д тусгай зөвшөөрөл шаардлагатай байна.

## Шигтгээ 2

...“Судалгаа, үнэлгээ, бодлогын нөлөөллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Мөн сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнтэй холбоотой бэрхшээл гарч байсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс мэргэжлийн нийгэмлэг сургалт явуулах зөвшөөрлийг 18 байнга авдаг. 2 жилийн өмнө энэ зөвшөөрлийг авахад сургалтын кодтой байх ёстой гэсэн шалгуур тавьсан. Гэхдээ бүртгэлийн гэрчилгээ дээр Эрүүл мэндийн салбарын мэргэжилтний мэдлэг чадварыг дээшилүүлэх, нотолгоонд суурилсан бодлого хөтөлбөр боловсруулах чиглэлээр бүртгэгдсэн байхад заавал тусдаа сургалт гэсэн өөр код авах ёстой гэсэн бэрхшээлтэй түлгэрч байсан” – ТББ-ын төлөөлөлтэй хийсан ФБЯ оролцож

- Мөн төрийн байгууллагаас үйл ажиллагааг хязгаарлах, дарамт шахалт үзүүлэх тохиолдол гарч байна. Тухайлбал, төрийн үйл ажиллагаа, төсвийн хяналт шалгалт үнэлгээ хийдэг ТББ-д дарамт үзүүлэх, төсвөөс санхүүжилт авч буй байгууллагад шахалт үзүүлэх, зарим чиглэлийн үйл ажиллагаанд ТЕГ хяналт шалгалт хийх, зөвшөөрөл олгохгүй байх гэх мэтийг дурдаж байсан.

### **Шигтгээ 3**

-... “Үйл ажиллагааны төрөл хэлбэрийг ТББ-ууд нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг, төрд хяналт тавьдаг, төрийн үйл ажиллагааг үнэлдэг болон төрийн үзүүлж чадахгүй байгаа үйлчилгээг үзүүлдэг гэж ангилж ирсэн. Одоо энэ асуудал дээр анхаарах, илүү нарийвчлах ёстой ... ТББ-ын үйл ажиллагаанд хяналт тавих, хязгаарлахаар хуулийн заалтууд орсон байгаа. Гэхдээ аль хэдийн Захиргааны хэргийн хуулиар бидний үйл ажиллагааг хянаад, зохицуулж ирсэн. Жишээлбэл, нийтийн эрх ашигийг төлөөлөөд нэхэмжлэл гаргахад биднээс сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны тайлан, УБЕГ, үйл ажиллагааны чиглэлтэй нийцэж байгаа эсэх гэх мэт нэлээдгүй материалыг хянаж шалгаж байгаа. ... ТББ-ууд 1990-ээд оноос байгуулагдаад ТББ-ын тухайн хуулиар зохицуулагдаж байх үед улс орны нийгэм, эдийн засгийн байдлаас болоод үйлчилгээ үзүүлэх, шинэ санаа, шинэ загвар оруулах, шинэ хууль, үзэл санаа оруулах чиглэлээр үйл ажиллагаагаа түлхүү явуулж байсан бол одоо улс орны хөгжлийн шаардлагаас болоод илүү төрд хяналт тавих, төрийн эрх мэдлийг хязгаарлах, төрийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх, тендер худалдан авалтад мөрдлөг мөшгөлт хийх, авлига хээл хахуулийн түвшинийг хөндлөнгөөс тодорхойлох, үнэлэх, бодлого хэрэгжилтийн үнэлгээг хийж байх чиг үүрэг рүү хөгжик байх шиг байна. Энэ чиглэл хэлбэрийг хуульд оруулбал зүйтэй. – ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ФБЯ, оролцогч Б9

- Мөн хуулийн зохицуулалтаар нь тухайлсан нэг үйл ажиллагаа эрхлэх ТББ-д тавих шалгуурыг нэмэгдүүлэх хандлага байна. Иймд зарим нэг онцгой ач холбогдол бүхий үйл ажиллагааг эрхлэх эрх, эрх чөлөөг нарийвчлан хуульчилж, хамгаалах шаардлагатай байгаа тухай мөн зарим ТББ-ын төлөөлөл хэлж байлаа.

## БҮЛЭГ 2. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХИ

### 2.1. Үүсгэн байгууллагчид ба удирдах зөвлөл

Төрийн бус байгууллагын удирдлага нь үүсгэн байгуулагчаас бүрдсэн 5 ба түүнээс дээш хүнтэй удирдах зөвлөлтэй, гишүүдтэй болон гишүүдгүй байж болно. Хэрвээ сан бол хяналтын зөвлөлтэй байхыг шаарддаг. Ихэнх тохиолдолд ТББ нь хувь хүмүүсийн сайн дурын нэгдэл дээр байгуулагддаг. Энэ нь хууль, албан болон албан бус дүрмээр зохицуулагддаг нийгэм, улс төр болон эдийн засгийн хүрээнд хоорондоо харьцаж буй зохион байгуулалттай буюу, зохион байгуулалтгүй иргэд, иргэдийн бүлэг юм. (Зохистой Хөгжлийн Жендер Төв, 2005)

Судалгаанд оролцогч байгууллагын 90 орчим хувь нь үүсгэн байгуулагч болон гүйцэтгэх албанад нь хувь хүн, үлдсэн хэсэг нь тодорхой нэг байгууллагад ажилладаг хүмүүс байна.

График 8. Үүсгэн байгуулагч болон гүйцэтгэх алба, хувиар




Үүсгэн байгуулагдаад удаагүй, үйл ажиллагаа нь бүрэн тогтворткоогүй, жижиг ТББ-уудад үүсгэн байгуулагч, удирдах зөвлөлийн бие бүрэлдэхүүн нь гүйцэтгэх удирдлагаа хэрэгжүүлдэг практик түгээмэл байгаа нь чанарын судалгаанаас харагдаж байв.

Үүний гол шалтгаан нь эдгээр ТББ-уудад санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал тул удирдлагын болон бусад урсгал зардлаа бууруулах шаардлагатай бөгөөд удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын энэхүү нийлмэл практик нь удирдлагын зардлаа бууруулах үндсэн арга, хэлбэр нь болж байна.

2005 онд Ардчиллын боловсрол төвөөс ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүдийн бүтцэд төр засгийн 22.0%, бизнесийн салбарын 16.0%, ЕБС болон их дээд сургуулийн багш нар 7.0%, олон улсын байгууллагын 7.0%, улс төрийн намын гишүүд 5.0%, УИХ-ын гишүүд 3.0% гэсэн төлөөлөлтэй байна гэж дүгнэжээ (Ардчиллын боловсрол төв, 2005).

Харин энэхүү судалгааны үр дүнг харвал дээрх төлөөлөл дангаар 15 хүрэхгүй хувийг эзэлж байгаа нь харагдаж байна. Мөн судалгаанд хамрагдсан байгууллагуудын удирдах зөвлөлийн гишүүд хүйсийн хувьд тэнцүү харьцаатай байна.


**График 9. Удирдах зөвлөлийн гишүүдийн тоо**



Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 70.4% буюу 481 байгууллага нь 1-5, 23.4% буюу 160 байгууллага нь 6-10, 4.1% буюу 2 байгууллага нь 11-15 удирдах зөвлөлийн гишүүнтэй бол үлдсэн хувь нь 16-аас дээш удирдах зөвлөлийн гишүүнтэй байна.

Удирдах зөвлөлийн гишүүдийг хүйсээр нь ангилбал, 1-5 удирдах зөвлөлийн гишүүдтэй байгууллагуудын 49.2%, 6-10 удирдах зөвлөлийн гишүүдтэй байгууллагуудын 46.6%, 11-15 удирдах зөвлөлийн гишүүдтэй байгууллагуудын 43.3%, 16-20 гишүүдтэй байгууллагуудын 63.5%, 21-25 удирдах зөвлөлийн гишүүдтэй байгууллагуудын 58.5%, 26-аас дээш удирдах зөвлөлийн гишүүдтэй байгууллагуудын 44.0% нь эмэгтэй гишүүдтэй байна.


**График 10. Удирдах зөвлөлийн гишүүд, хүйсээр**



2005 онд ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүний тоог Ардчиллын боловсролын төвөөс гаргасан байдаг. Уг тайланд ТББ-уудын 47.0 хувь нь 5, 22.0 хувь нь 9, 17.0 хувь нь 7 гишүүнтэй байжээ. Үлдсэн нь 10 хувь 11-с олон гишүүнтэй байжээ (Ардчиллын боловсрол төв, 2005). Үүнээс харахад 2005 оныг бодвол 2020 оны байдлаар удирдах зөвлөлийн гишүүний дундаж тоо цөөрсөн гэж хэлж болохоор байна.

Удирдах зөвлөлийн насны бүлгийг харахад 59.0% нь 35-54 насынхан байна.


**График 11. Удирдах зөвлөлийн гишүүдийн насны бүтэц, хувиар**



Ихэнх байгууллагын удирдах зөвлөл нь тогтмолжсон бөгөөд 37.3% нь улирал бүр, 32.9% нь жил бүр удирдах зөвлөлийн хурлаа тогтмол хуралдуулдаг байна. Эдгээр байгууллагудаас 87.9% нь бүх гишүүдийн хурал дээр удирдах зөвлөл нь үйл

ажиллагааны төлөвлөгөө биелэлт, санхүүгийн тайлангаа танилцуулдаг байна. Харин 11.6% нь удирдах зөвлөл огт үйл ажиллагаа явуулдаггүй гэжээ.

#### **График 12. Удирдах зөвлөлийн хуралдах давтамж, хувиар**



Мөн цөөн тооны ажилтантай (1-5 ажилтантай), орон нутагт үйл ажиллагаа явуулж буй жижиг ТББ-үүдүүн хувьд УЗ нь жилд нэг эсвэл түүнээс цөөн удаа хуралдах, эсвэл огт үйл ажиллагаа явуулахгүй байх тохиолдол илүү байгаа бол 9 болон түүнээс дээш тооны ажилтантай ТББ-ын удирдах зөвлөл нь жилд 2 болон түүнээс олон удаа хуралдах нь түгээмэл байна.

Үр дүнгээс харахад ТББ-ын төлөөллийн ихэнх нь удирдлагын болон ажилтны ёс зүйн журам, санхүүгийн журам, үйл ажиллагааны дотоод журамтай бол 17.8% нь батлагдсан дурэм журамгүй байна.


### *График 13. Батлагдсан дүрэм, журам, хувиар*



ТББ-ын үйл ажиллагаа улс төр, шашин, эдийн засгийн бүлэглэлээс ангид байж чаддаг гэж 78.8 % нь хариулсан байна.

Мөн байгууллагын 27.1% дотоод (өөрсдөө хийж байгаа аудит), 29.0% нь хөндлөнгийн (аудитын эрхтэй, санхүүгийн байгууллагаар) хийлгэсэн байна.

График 14. Аудит хийлгэсэн байдал, төрлөөр




### 2.1.1. Гишүүнчлэл

ТББ-ын гишүүнчлэлийн тоо өмнөх судалгааны дүнгээс өссөн байна. Хамрагдсан байгууллагуудын 47.6% нь хувь хүмүүс, хуулийн этгээдийн гишүүнчлэлтэй бөгөөд нийтдээ 27.0 мянга гаруй хуулийн этгээд, 84.0 мянга гаруй хувь хүний гишүүнчлэлтэй байна. Үүнтэй төстэй 2005 онд 555 байгууллагыг судлахад тэн хагас нь 50-иас илүүгүй гишүүдтэй, 25.0% нь 50-100 гишүүдтэй байхад 2 орчим хувь нь 100-аас дээш гишүүдтэй байгууллагууд байна гэжээ (Ардчиллын боловсрол төв, 2005).

Хувь хүний гишүүнчлэлтэй ТББ-уудын гишүүдийнх нь насын бүлгийг харахад аль ч насын иргэдэд ижил тэгш үйлчилдэг байгаа нь доорх графикаар харагдаж байна.

График 15. Гишүүдийн насын бүтэц, хувиар



Чанарын судалгаанд ГҮТББ хамрагдаагүй. Энэ нь ч утгаараа ФБЯ-д хамрагдсан ТББ-ууд бүгд нийгэмд үйлчилдэг буюу нийтэд тустай үйл ажиллагааг голчлон хэрэгжүүлдэг гэж үзэж болно.

#### Шигтгээ 4

...Манай байгууллагын төрөл, хэлбэр маш замбараагүй байна. Гишүүдтэй болохоор гишүүдээ үйлчилдэг ч юм шиг, эрхэлж буй үйл ажиллагаагаа харах нийтэд үйлчилж, ... эрхийн төлөө яваад байгаа ч юм шиг, холбоо, эвсэл гээд аль хэлбэр ангилал, төрөлд хамаараад байгаа нь тодорхойгүй. Иргэний нийгмийн байгууллага гэж залуучуудын хөгжлийн хуульд орсон, Төр, хуеийн хэвшлийн талаар төрөөс баримтлах бодлогод ТББ-ыг хувийн хэвшлийн байгууллага гэх, холбоо, сан зэрэг ангилал, нэр маш замбараагүй байгаа... - ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ФБЯ, оролцогч Б9

Зарим нэг байгууллагад гишүүдэд чиглэсэн үйл ажиллагаа давхар явуулж байна. Гэвч эдгээр ТББ-ын зарим нь гишүүнчлэлтэй боловч өмнө хэлж байсанчлан гишүүнчлэл тухай байгууллагын шийдвэр гаргалт, удирдлага, зохион байгуулалтад хамааралгүй, тодорхой үйл ажиллагаанд хамрагдах, үйлчилгээ авахаар хязгаарлагдаж байна.

#### Шигтгээ 5

...Гишүүд нь нь манай хөгжлийн хөтөлбөрийн нэг хэсэг, тухайн жилд төлбэр төлөөд гишүүнээр элсэж, манай байгууллагын зүгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд урилгаар оролцох эрх авдаг. Жилд 17 орчим гишүүнийг үйл ажиллагаагаа тэлэх, ... үйл 23 ажиллагаанд оролцуулах зорилгоор элсүүлдэг... - ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ФБЯ, оролцогч Б1

### 2.1.2. Гүйцэтгэх удирдлага ба сайн дурын ажилтан

Өмнө дурдсанчлан, судалгаанд хамрагдсан ТББ-уудад удирдах зөвлөл нь гүйцэтгэх удирдлагаа давхар хэрэгжүүлэх практик түгээмэл байна. Гүйцэтгэх удирдлагаас гадна ТББ-д дунджаар 5,7 ажилтан ажиллаж байна (хамгийн багадаа 1, хамгийн ихдээ 35 ажилтантай байна). Нийт ТББ-ын 70.4% нь 5 болон түүнээс бага буюу дунджаас цөөн тооны ажилтантай байна. Харин 92.8% нь 1-9 ажилтантай байгаа нь Бизнес регистрийн сангийн статистиктай (90.4%) дүйж байна.


Судалгаанд хамрагдсан ТББ-уудын гүйцэтгэх албаны ажилтны тоог бүтэн болон хагас цагийн ажилтнаар ангилан дараах графикт харууллаа. Үүнд 1-4 гүйцэтгэх албаны ажилтантай байгууллагуудын 51.5% нь бүтэн, 40.6% нь хагас цагийн ажилтантай, 5-7 гүйцэтгэх ажилтантай байгууллагуудын 14.7% нь бүтэн, 11.8% нь хагас цагийн ажилтан байна. Харин 8-аас дээш гүйцэтгэх ажилтантай байгууллагуудын 10.2% нь бүтэн, 7.0% нь хагас цагийн гүйцэтгэх албаны ажилтан байна.

График 16. Гүйцэтгэх албаны ажилтан, төрлөөр



Дараах графикт 1-4 санхүүгийн ажилтантай ТББ-уудын 75.0% нь бүтэн, 81.2% нь хагас цагийн, 6-аас дээш санхүүгийн ажилтантай байгууллагуудын 14.9% нь бүтэн, 9.4% нь хагас цагийн ажилтантай байна.


График 17. Санхүүгийн ажилтан, төрөл



1-5 түр болон гэрээт ажилтантай байгууллагуудын 68.3% нь бүтэн, 71.1% нь хагас цагийн, 5-7 түр болон гэрээт ажилтантай байгууллагуудын 12.2% нь бүтэн, 12.6% нь хагас цагийн ажилтантай байна.


Түүнчлэн 8-аас дээш түр болон гэрээт ажилтантай байгууллагуудын 19.3% нь бүтэн, 16.3% нь хагас цагийн ажилтантай байлаа.

График 18. Түр болон гэрээт ажилтан, төрөл



Доорх графикт ТББ-уудын сайн дурын ажилтнуудыг бүтэн болон хагас цагаар ангилан харуулав.

*График 19. Сайн дурын ажилтан, төрлөөр*




Нийт ТББ-уудын 75% нь 10 хүртэлх сайн дурын ажилтантай, харин 25% нь 10-аас дээш сайн дурынхантай ажиллаж байгаа нь ТББ-ууд сайн дурынхан болон сайн дурын үйл ажиллагааг өргөнөөр дэмжиж байгааг харуулж байна.

#### Шигтгээ 6


-...2020 онд Сайн дурынхны байгууллагуудын сүлжээний 19.694 сайн дурынхан 1,418,582 цаг сайн дураар ажиллаж, Монгол Улсын эдийн засагт 3,4 тэрбум төгрөгтэй дүйцэхүйц хувь нэмрийг оруулжээ. Харамсалтай нь, 2020 онд сайн дурын үйл ажиллагаа нь цар тахлаас болж 2019 оныхос 30 орчим хувиар буурсан үзүүлэлттэй. – Тоон судалгааны мэдээ

График 20. Байгууллагын үйл ажиллагаа улс төр, шашин, эдийн засгийн бүлэглэлээс ангид байж чаддаг эсэх



Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 21.2% буюу 1/5 нь төрийн бус байгууллагын үйл ажиллагаа улс төр, шашин, эдийн засгийн бүлэглэлээс ангид байж чаддаггүй гэжээ. Үүний 90.0% нь Улаанбаатарт, 10.0% нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд боловсролын бусад үйлчилгээ болон аль ч ангилалд ороогүй чиглэлүүд эзэлж байна.


График 21. Улс төрийн эрх мэдэлтнийг удирдах зөвлөлд оруулах нь зөв эсэх, хувиар



Нийт байгууллагуудын 26.4% буюу 1/4 нь төрийн эрх мэдэл бүхий албан тушаалтныг удирдах зөвлөлд урьж оролцуулах нь зөв гэж үзэж байна. Эдгээр байгууллагын 68.3% нь Улаанбаатарт, 31.7% нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.

Улс төрийн эрх мэдэлтнийг удирдах зөвлөлдөө оруулах нь зөв гэж үзэж байгаа байгууллагуудын ихэнх нь сургалт, зөвлөгөө, мэдээллийн болон тусlamж үйлчилгээний хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

График 22. Төсөл, тендерт оролцохын тулд албан бус зардал гаргадаг эсэх, хувиар



Түүнчлэн төсөл, тендерт оролцохын тулд албан бус зардал буюу хууль, дүрэм журамд заагаагүй, байгууллага, албан тушаалтны тухайн үеийн хүсэлт, шаардлагын дагуу төлөх төлбөрийг 14.8% буюу 1/7 нь гаргадаг гэж хариуллаа. Эдгээрийн 67.3% нь Улаанбаатарт, үлдсэн 32.7% нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байлаа.

Үйл ажиллагааны чиглэлийн хувьд дээрх ангилалд ороогүй үйл ажиллагаа, боловсролын бусад үйлчилгээ болон байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа чиглэлийн байгууллагууд нь албан бус зардал илүү гаргадаг гэсэн үр дүн харагдаж байна. Эдгээрээс

харахад ТББ-ын засаглалд шударга байдлыг бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Засаглалын асуудлыг бид нэг л удаагийн ФБЯ-ын хүрээнд хэлэлцүүлэх боломжтой байв. Гэсэн хэдий ч засаглал, удирдлага зохион байгуулалтын бүтцийн хувьд өөрсдийн онцлог, нөөц бололцоотой уялдсан харилцан адилгүй туршлагууд байгааг харж болно. ФБЯ-аас дараах үндсэн асуудлууд ажиглагдav. Үүнд:

- Томоохон холбоод, ОУ-ын байгууллагын гишүүнчлэлтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас бусад нь Удирдах зөвлөл нь эрх барих дээд байгууллага гэж явж байна. Зарим байгууллага нь гишүүнчлэлтэй боловч гишүүд нь зөвхөн сургалт, үйлчилгээ авах зэрэг үйлчилгээний гишүүнчлэлийн хэлбэртэй байх ба байгууллагын дотоод удирдлагад оролцогүй байгууллага байна.
- Гадаадаас санхүүжилттэй жижиг ТББ-уудын хувьд удирдлагын бүтэц тодорхойгүй байна. Ихэвчлэн үүсгэн байгуулагч, түүний хяналт доор гүйцэтгэх удирдлага гэсэн хэлбэртэй, эсвэл үүсгэн байгуулагч нь өөрөө гүйцэтгэх удирдлагаа хэрэгжүүлдэг тохиолдууд байна. Мэдээж энэ нь үүсгэн байгуулагч нь хувь хүн үү эсвэл хуулийн этгээд үү гэдгээс хамаарна.
- Мөн жижиг ТББ болон үйл ажиллагаа явуулаад удаагүй ТББ-уудад удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын эрх, үүргийн зааг ялгаа бүдэг, удирдах зөвлөл нь өөрсдөө гүйцэтгэх удирдлагаа хэрэгжүүлэгч байх тохиолдол байна.
- Үйл ажиллагаа нь тогтвортсон, үндэсний хэмжээний томоохон ТББ-ууд л хяналтын зөвлөлийн бүтэц байна. Мөн хөндлөнгийн аудит хийлгэдэг туршлага цөөнгүй байгаа ч байгууллага тус бүрийн аудит хийлгэж буй шаардлага нь харилцан адилгүй. Зарим нь ОУ-ын дүрмийн шаардлагаар, зарим нь өөрсдийн засаглалын шалгуураар, зарим нь олон нийтийн өмнөх хариуцлагын хүрээнд, зарим нь тусгайлсан хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд хийгддэг байна.


## 2.2. ТББ-ын санхүүжилт ба татвар

### 2.2.1. ТББ-ын зардал ба хөрөнгө

Судалгаанд хамрагдсан нийт байгууллагын 88.4% нь өөрийн байргүй, түрээсийн болон төлбөргүйгээр хувийн, эсвэл төрийн байр ашиглаж үйл ажиллагааг явуулж байна.

Доорх графикт төрийн бус байгууллагуудын байрны төрлийг орон нутгаар ялгаж нь харууллаа. УБ хотын 80.5% нь, орон нутагт 78.7% нь өөрийн байргүй байна.

График 23. Байрны төрөл, байршилаар, хувиар




### Шигтгээ 7

-... 2019 оноос УБЕГ болон банк санхүүгийн байгууллагаад эцсийн өмчлөгчийг бүртгэхэд анхаарч байна. ТББ-ын бүртгэл хийхдээ хөрөнгийн эх үүсвэргүй бүртгэх буюу хөрөнгийн хэмжээг 0₹ гэж бүртгэдэг. Учир нь хуульд тусгайллан заадаггүй. Үүнээс болж хөрөнгийн маргаанууд гарч шүүхээр орж байгаа жишээнүүд бий. - ФБЯ, оролцогч талууд, 2020.

Өөрийн хөрөнгөтэй ТББ-ууд 1996 онд 29.0% байсан бол 2000 онд 52.0% болж өссөн байна. Тухайлбал, Монголын улаан загалмайн нийгэмлэг, Монголын худалдаа, аж үйлдвэрийн үндэсний танхим, “Зориг” сан, Монголын үндэсний олимпийн хороо, Монголын хэвлэлийн хүрээлэн зэрэг байгууллага 60.0 саяас дээш төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байхад олонх буюу 55.8% нь 5.0 сая хүртэл төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна. Хөрөнгийн бүтцийг авч үзвэл 40.0-өөс дээш сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байгууллагууд өөрийн гэсэн байр, бусад үндсэн хөрөнгөтэй байхад үлдэх хэсэг нь үйл ажиллагаа явуулах оффисын тавилга, техник хэрэгслийн төдий хөрөнгөтэй ажээ. Ер нь бүртгэлтэй ТББ-уудын дөнгөж 10 орчим хувь нь өөрийн байртай гэсэн мэдээлэл байна. (УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЗӨВЛӨЛГӨӨ, БИЗНЕСИЙН ТӨВ, 2000)

Дийлэнх байгууллагуудын сүүлийн 3 жилийн орлого, зарлага болон үндсэн хөрөнгийн дундаж хэмжээ нь 0-50 сая төгрөг буюу орлого зарлага нь тэнцсэн үзүүлэлттэй харагдаж байна. Доорх графикаас Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын орлого болон зарлагын хэмжээ хөдөө, орон нутгийн байгууллагуудаас илүү өндөр харагдаж байна.

График 24. Сүүлийн 3 жилийн орлого, зарлага, үндсэн хөрөнгийн дундаж хэмжээ, байршилаар, хувиар




Сүүлийн 3 жилийн орлого, зарлагын дундаж хэмжээг гишүүнчлэлтэй байгууллагуудаар үзүүлэв. Зарлагын жилийн дундаж хэмжээний хувьд, хувь хүмүүст гишүүнчлэл олгодог байгууллагуудын 90.0% нь 0-50 сая төгрөг, 3.3% нь 51-100 сая төгрөг, үлдсэн хувь нь 101-ээс дээш сая төгрөг байдаг бол хуулийн этгээдэд гишүүнчлэл олгодог байгууллагуудын

76.3% нь 0-50 сая төгрөг, 14.9% нь 51-100 сая төгрөг, үлдсэн хувь нь 101-ээс дээш сая төгрөгийн жилийн дундаж зарлагатай байна.


Харин хувь хүмүүст гишүүнчлэл олгодог байгууллагуудын 89.2% нь 0-50 сая, 4.1% нь 51-100 сая, үлдсэн хувь нь 101-ээс дээш сая төгрөгийн орлогын жилийн дундаж хэмжээтэй бол хуулийн этгээдэд гишүүнчлэл олгодог байгууллагуудын 75.4% нь 0-50 сая, 14.9% нь 51-100 сая төгрөг, үлдсэн хувь нь 101-ээс дээш сая төгрөгийн орлогын жилийн дундаж хэмжээтэй байна.

*График 25. Сүүлийн 3 жилийн орлого зарлагын хэмжээ, гишүүнчлэлээр, хувиар*



ТББ-уудын зардлын задаргааг үйл ажиллагаа явуулж буй байршилаар ангилж харууллаа. Үр дүнгээс харахад үйл ажиллагааны зардал дийлэнх хувийг эзэлж байгаа ба тэр дундаа орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хувьд нийт зардлын 70.6%-ийг энэхүү зардалд зарцуулж байна.

*График 26. Байгууллагын үйл ажиллагааны зардлын төрөл хувиар*



### Шигтгээ 8

...Шинээр өргөн барьж буй АТБХЭтХ-ийн санхүүжилтийг хэд хэдэн байдлаар томьёолж байна. Үүнд хандив тусламж, гишүүний татвар, аж ахуйн үйл ажиллагааны орлого, иргэний нийгмийг дэмжих сангаас олгох санхүүжилт, төлбөртэйгээр нийтэд тустай үйл ажиллагаа, төрийн чиг үүргийг хэрэгжүүлсний төлбөр, 7-д бусад гэж оруулсан (ФБЯ - Оролцогч талууд, 2020).

ТББ-уудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд захиргааны болон цалингийн зардлыг дэмждэггүй. Төрөөс үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд шалгуур тавьж магадлан, аудит байдаг хэр нь, чадавхийг дэмжсэн зардал огт багтдаггүй нь олон ТББ-ын үйл ажиллагааг 29 масалдахад хүргэдэг. (ФБЯ - Оролцогч талууд, 2020)

Гишүүнчлэлтэй байгууллагуудын хувьд сүүлийн 3 жилийн байдлаарх зардлын хэмжээг задалж харууллаа.

График 27. Сүүлийн 3 жилийн зардлын төрөл, гишүүнчлэлээр, хувиар




Хуулийн этгээдэд гишүүнчлэл олгодог байгууллагын хувьд цалингийн зардал нь хувь хүмүүс гишүүн нь болдог байгууллагаас өндөр хувьтай харагдаж байна. Харин үйл ажиллагааны зардал болон санхүүжилт босгохтой холбоотой гарах зардал нь хувь хүмүүст гишүүнчлэл олгодог байгууллагад илүү байна.

## 2.2.2. Төрийн бус байгууллагын орлого ба санхүүжилт

ТББ-үүд гишүүний татвар, хандив, иргэд, ААНБ-ын хандив, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого, төслийн гадаад санхүүжилт зэргээс дийлэнх орлогоо бүрдүүлдэг байна.

График 28. Орлогын эх үүсвэр, хувиар



Улаанбаатар хотын ТББ-уудын дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого нь орон нутгийн ТББ-уудаас илүү байна. Харин гадаад төслийн санхүүжилтээс орлогын эх үүсвэрээ бүрдүүлж байгаа байгууллагууд нь илүүтэй орон нутгийн ТББ-ууд байна.

#### Хүснэгт 4. Орлогын эх үүсвэр, байршилаар, хувиар

№	Орлогын эх үүсвэр	Улаанбаатар	Орон нутаг
1	Гишүүний татвар, хандив	39.3%	39.5%
2	Иргэд, ААНБ-ын хандив	32.8%	34.5%
3	Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого	36.0%	15.8%
4	Зээлийн хөрөнгө	1.4%	1.1%
5	Өвийн хөрөнгө	1.8%	0.6%
6	Улсын төсвөөс олгосон хөрөнгө	6.1%	6.8%
7	Төслийн санхүүжилт (гадаад)	18.6%	22.6%
8	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах (тендер)	5.1%	3.4%
9	Бусад	11.7%	5.6%

ГҮТББ-ын хувьд гишүүний татвар, хандиваас орлого бүрдүүлэх байдал давамгай байна. Харин нийгэмд, нийгэмд болон гишүүдэд үйлчилдэг байгууллагууд нь иргэд, ААНБ-ын хандив, аж ахуйн үйл ажиллагаанаас олох орлого нь ГҮТББ-аас илүү байна.

#### Хүснэгт 5. Орлогын эх үүсвэр, байгууллагын төрлөөр, хувиар

№	Орлогын эх үүсвэр	Нийгэмд үйлчилдэг	Гишүүдэд үйлчилдэг	Нийгэмд болон гишүүдэд
1	Гишүүний татвар, хандив	20.0%	84.4%	49.7%
2	Иргэд, ААНБ-ын хандив	36.6%	22.1%	33.7%
3	Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого	38.2%	15.6%	25.4%
4	Зээлийн хөрөнгө	1.6%	0.8%	1.1%
5	Өвийн хөрөнгө	2.1%	0.0%	1.1%
6	Улсын төсвээс олгосон хөрөнгө	7.4%	1.6%	7.2%
7	Төслийн санхүүжилт ( гадаад)	25.0%	6.6%	17.1%
8	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах (тендер)	4.7%	2.5%	6.1%
9	Бусад (Бичих)	11.6%	9.0%	7.7%

Хэдийгээр тоон судалгаагаар гишүүдийн хандив, татвар, иргэн, ААНБ-ын хандив орлогын тэргүүлэх эх сурвалжуудаар дурдагдсан байгаа хэдий ч ФБЯ-аар ТББ-уудын хамгийн түгээмэл санхүүжилтийн эх үүсвэр нь ОУБ-ын санхүүжилт, тэтгэлэг, гадаадын төслийн санхүүжилт байна.

Байгууллагын онцлогоос хамаарч зарим ТББ-ууд төрийн чиг үүргийг гүйцэтгэсэн, эсвэл тендерийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэрэг хэлбэрээр төрөөс санхүүжилт авах явдал мөн түгээмэл байна.

Үүнээс гадна зарим ТББ-ууд нь crowdfunding, аж ахуйн зарим үйл ажиллагаа, хандивын дуудлага худалдаа зэрэг түгээмэл биш орлогын эх үүсвэрийг мөн үр дүнтэй ашиглаж байна.

Хувийн хэвшил, ААНБ, иргэдийн хандив нь илүү урлаг соёлын, хүмүүнлэгийн болон нийгмийн үйлчилгээний шинжтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад ажиглагдаж байна. Харин төрд хяналт тавьдаг, иргэний дуу хоолойг хүргэдэг, иргэдийн эрх ашгийг төлөөлдөг, хамгаалдаг чиглэлийн байгууллагуудад иргэд, ААНБ-ын хандивын орлого төдийлөн байхгүй байна.

2000 оны судалгаагаар ТББ-ын дотоод гадаад нөөцийн харьцаа 6.7:93.3 буюу ихэнх нь гадаад эх үүсвэрийн хүчинд ашиглаж байна. Энэ нь нэг талаас ТББ-ууд нь санхүүгийн бэрхшээлтэй ч нийгмийн салбарт донор байгууллагуудаас амласан зээл, тусlamжийг цаг алдалгүй авч бүрэн ашиглаж чадахгүй байна гэж дүгнэжээ (УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЗӨВЛӨЛГӨӨ, БИЗНЕСИЙН ТӨВ, 2000). Харин 2005 онд ТББ-ын санхүүжилтийн 59.5% нь гадаадын донор байгууллага, 27.9% нь өөрсдийн үйл ажиллагааны орлого, 12.6% нь хандив, дэмжлэг гэсэн эх үүсвэрээс бүрдэж байсайн байна. (Ардчиллын боловсрол төв, 2005)

#### Шигтгээ 9

... нь ТББ-ын санхүүжилтийн хязгаарлагдмал бололцоо нь эргээд үйлчилгээний чанар, үнэлгээнд нөлөөлж болох юм. Тийм учраас батлахаар яригдаж буй хуулийн 3 төсөлд ТББ-ын санхүүгийн асуудлыг сайн шийдэж өгөх хэрэгтэй гэж харж байна. Тэр тусмаа үйл ажиллагааг магадлан итгэмжилнэ гэж заасан байдаг, үйлчилгээний зардлыг олгох тал дээр бодолцох хэрэгтэй (ФБЯ - Оролцогч талууд, 2020).

Судалгааны хүрээнд сонгогдсон нийгэмд үйлчилдэг 10 ТББ-ын төлөөлөлтэй уулзахад тэдний үйл ажиллагааны санхүүжилтийн дөнгөж 5.0-10.0% нь төрөөс (төрийн чиг үүргийг тэрээлэх тохиолдолд), 90.0-100.0% гадаадын төслийн санхүүжилт байдаг байна.

(“Баасанжав консалтинг” ХХК, 2017) ТББ-ын нэг гол санхүүгийн эх үүсвэр бол хандив юм. Хандивлагч иргэн, аж ахуйн нэгжийг холбогдох татвараас чөлөөлөх, хөнгөлөх зохицуулалтгүйгээс хандив өгөх сонирхол дэмжигдэхгүй байна. ТББ нь үл хөдлөх хөрөнгөтэй тохиолдолд хөрөнгийн татвар ногдуулах нь ТББ-ыг өөрийн байртай болох сонирхолд сөрөг нөлөө үзүүлж байна. (“Баасанжав консалтинг” ХХК, 2017)

### 2.2.3. ТББ-ын хуримтлал


Судалгаанаас үзэхэд байгууллагуудын 4/5 нь ямар нэгэн төсөлгүй бол санхүүгийн эрсдлээс хамгаалсан хуримтлалгүй гэжээ. Оролцогчдын 20.4% нь хуримтлалын бодлоготой бөгөөд ямар ч төсөлгүй байхад санхүүгийн эрсдлээс хамгаалах хуримтлалтай буюу 4.8% нь 1 сар хүртэл, 7.2% нь 1-6 сар хүртэл, 2.3% нь 6 сараас 1 жил хүртэл, 1.3% нь 1 жилээс дээш хугацаанд тэснэ гэсэн тооцоололтой байна. Харин огт төсөлгүй байхад санхүүгийн эрсдлээс хамгаалсан хуримтлалгүй байгууллагууд 84.3% нь байна.

**График 29. Санхүүгийн эрсдлээс хамгаалсан хуримтлалтай эсэх, байрилаар, тоогоор**



Нийгэмд үйлчилдэг байгууллагуудын хувьд санхүүгийн эрсдлээс хамгаалсан бодлого дутмаг байгааг дараах үр дүнгээс харж болно. Гишүүнчлэлтэй байгууллагыг бодвол хуримтлалын хувь нь харьцангуй бага байна.

**График 30. Санхүүгийн эрсдлээс хамгаалсан хуримтлалтай эсэх, байгууллагын төрлөөр, хувиар**



Өмгөөлөл, мэдээллийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нь төсөл, хөтөлбөргүй байхад 1 сар хүртэл хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж чадна гэсэн бол сурталчилгаа, тусламжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хувьд 1 жилээс дээш хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах хуримтлалтай гэжээ.

**Хүснэгт 6. Санхүүгийн эрсдэлээс хамгаалсан хуримтлалтай эсэх, үйл ажиллагааны хэлбэрээр, хувиар**

№	Үйл ажиллагааны хэлбэр	Хуримтлалтай 1 сар тэнсэ	Хуримтлалтай 1-6 сар тэнсэ	Хуримтлалтай 6 сараас 1 жил тэнсэ	Хуримтлалтай 1 жилээс дээш	Хуримтлалгүй
1	Сургалт	69.7%	81.6%	75.0%	44.4%	68.6%

2	Судалгаа	27.3%	49.0%	56.3%	11.1%	42.7%
3	Зөвлөгөө	48.5%	51.0%	62.5%	33.3%	53.5%
4	Нэлөөлөл	36.4%	44.9%	50.0%	22.2%	38.9%
5	Өмгөөлөл	18.2%	12.2%	6.3%	0.0%	9.2%
6	Тусlamж үйлчилгээ	54.5%	40.8%	43.8%	66.7%	39.2%
7	Мэдээллийн үйлчилгээ	51.5%	28.6%	31.3%	11.1%	45.3%
8	Сурталчилгаа	27.3%	14.3%	31.3%	33.3%	24.0%
9	Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний мониторинг	12.1%	12.2%	37.5%		7.6%
10	Улсын болон орон нутгийн төсвийн хяналт	6.1%	6.1%	25.0%		2.8%
11	Бусад					1.2%

Оролцогчид ТББ-ын санхүүгийн тогтвортой байдалд дараах асуудлууд тулгамддаг гэж илэрхийлж байв. Үүнд:

- Хамгийн том бөгөөд түгээмэл дарамт нь НДШ, түнтэй холбоотой торгуулийн асуудал байна. ТББ-ын хүний нөөц нь тогтмол ажилладаг цөөн тооны үндсэн ажилтнаас гадна хагас цагийн, түр зуурын, сайн дурын эсвэл богино хугацааны гэрээт ажилтнуудаас бүрддэг. Жил ирэх тутам нэмэгдэж буй НДШ-ийн хувь хэмжээ болон ажил олгогчийн НДШ төлөх нь ТББ-ын хувьд хамгийн хүндрэлтэй асуудал болдог.
- Хамгаалах байр зэрэг нийтэд тустай үйл ажиллагаа явуулах зорилгоор барьсан үл хөдлөх хөрөнгийн татвар бас төлөх болдог.
- Мөн гаалийн албан татварын асуудал нь зарим байгууллагад хүндрэлтэй байдаг байна. Гадны тусlamжаар орж ирж байгаа тусlamжийн бараа бүтээгдэхүүнд гаалийн татвар ноогдуулдгаас болж ТББ нь эргээд санхүүгийн дарамтад ордог.
- Үүнээс гадна олон нийт, иргэд, ААНБ-аас хандив цуглуулдаг ТББ-үүд нь хандивлагчдыг татвараас чөлөөлөх тогтолцоо байдаггүйг хүчтэй шүүмжилж байв.


#### 2.2.4. ТББ-ын татвар ба хөнгөлөлт чөлөөлөлт

ТББ-үүд 2002-2004 онуудад улсын төсөвт 2,851.5 төгрөгийн татвар төлсөн бол (Ардчиллын боловсрол төв, 2005), 2017-2019 онуудад 13,718,791 төгрөг болж өссөн байна. 2019 оны байдааар бүртгэлтэй нийт ТББ улсад 13,718,791 төгрөгийн татвар, 52,801,059 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлжээ<sup>1</sup>.

Судалгаанд хамрагдсан ТББ-үүдын 10.2% нь 108,970 мянган төгрөгийн ААНБ-ын орлогын албан татвар, 23.6% нь 446,670,000 төгрөгийн ХХОАТ-ыг 2019 онд төлжээ. Мөн 2.5% нь үл хөдлөх хөрөнгийн татвар, газар ашигласны татварын 91,908,000 төгрөгийг төлсөн байна.

**График 31. 2019 онд төлсөн нийт татварын хэмжээ, байршилаар, төгрөгөөр**

<sup>1</sup> Сангийн яамны албан мэдээнээс



Судалгаанд хамрагдсан ТББ-уудын 2019 онд төлсөн татварын дундаж хэмжээ нь ААНБОАТ-т 160,000 төгрөг, ХХОАТ-т 654,000 төгрөг, бусад татваруудад 5,406,000 төгрөг төлжээ. Нийгэмд болон гишүүдэд үйлчилдэг байгууллагуудын төлсөн татварын дундаж хэмжээ нь өндөр байна.

#### **Хүснэгт 7. 2019 онд төлсөн татварын дундаж хэмжээ, байгууллагын төрлөөр, төгрөгөөр**

№	Татварын төрөл	Нийгэмд үйлчилдэг	Гишүүдэд үйлчилдэг	Нийгэмд болон гишүүдэд үйлчилдэг
1	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	154,000	93,000	215,000
2	Хувь хүний орлогын албан татвар	666,000	449,000	766,000
3	Бусад	846,000	9,475,000	11,174,000

Улаанбаатар хотын болон орон нутгийн ТББ-уудын төлсөн татварын дундаж хэмжээг үзүүлэв. Орон нутгийн ТББ-ууд болон Улаанбаатар хотын ТББ-уудын төлсөн татварын дундаж хэмжээ нь 4:3 харьцаатай байна.

#### **Хүснэгт 8. 2019 онд төлсөн татварын дундаж хэмжээ, байршилаар, төгрөгөөр**

№	Татварын төрөл	Орон нутаг	Улаанбаатар
1	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	194,000	148,000
2	Хувь хүний орлогын албан татвар	132,000	837,000
3	Бусад	238,000	9,025,000

2019 онд судалгаанд хамрагдсан ТББ-уудын 23.0% нь НДШ төлжээ. Дунджаар 986,000 төгрөгийн НДШ төлж, үүнээс ажил олгогч 455,000 төгрөгийн НДШ төлжээ. Доорх график төлсөн НДШ-ийн хэмжээг байгууллагын төрлөөр харууллаа.

#### **Хүснэгт 9. 2019 онд төлсөн НДШ-ийн дундаж хэмжээ, байгууллагын төрлөөр, төгрөгөөр**

№	НДШ	Нийгэмд үйлчилдэг	Гишүүдэд үйлчилдэг	Нийгэмд болон гишүүдэд үйлчилдэг
1	НДШ-ийн нийт дүн	785,000	804,000	1,530,000
2	Ажил олгогчийн төлсөн дүн	401,000	343,000	643,000

Судалгаанд оролцсон ТББ-ын дөнгөж 3.4 хувь нь 2015-2019 онд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал эдэлжээ. ХХОАТ-т дунджаар 1,426,000 төгрөг, ААНБ албан татварт дунджаар 1,000,000 төгрөг, үйл ажиллагааны төрлөөс хамаарсан татварт дунджаар 667,000 төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлт, урамшууллыг эдэлжээ.

#### **Хүснэгт 10. Хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн татварын төрөл, байршилаар, төгрөгөөр**

№	Хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн татварын төрөл	Улаанбаатар	Орон нутаг
1	Хувь хүний орлогын албан татвар	339,000	1,921,000
2	Үйл ажиллагааны төрлөөс хамаарч /шашин, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/	-	667,000

3	ААНБ албан татвар	500,000	1,167,000
---	-------------------	---------	-----------

Нийгэмд болон гишүүдэд үйлчилдэг байгууллагууд ХХОАТ болон ААНБ албан татвараас илүүтэй хөнгөлөгджээ.


**Хүснэгт 11. Хөнгөлөлт чөлөөлөлт эдэлсэн татварын төрөл, дундаж хэмжээ, байгууллагын төрөл, төгрөгөөр**

№	Татварын төрөл	Нийгэмд үйлчилдэг	Гишүүдэд үйлчилдэг	Нийгэмд болон гишүүдэд үйлчилдэг
1	Хувь хүний орлогын албан татвар	1,229,000	1,213,000	1,880,000
2	Үйл ажиллагааны төрлөөс хамаарч /шашин, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/	600,000	800,000	-
3	ААНБ албан татвар	500,000	-	2,500,000

### 2.3. ТББ-ЫН ТАЙЛАГНАЛТ


Төрийн бус байгууллагууд төрийн байгууллага, олон нийт, хандивлагч нарт зориулсан үйл ажиллагаа болон санхүүгийн хэд хэдэн төрлийн тайлан гаргадаг. Хандивлагч, олон нийт, удирдах зөвлөлд үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангаа танилцуулдаг. Мөн ивээн тэтгэгч байгууллагын төслийн санхүүжилт, мөн төрийн үйлчилгээ, тендерийн ажил гүйцэтгэсэн бол холбогдох тайлангууд тус тус нэмэгдэнэ. ТББ-ууд УБЕГ-т үйл ажиллагааны жилийн тайлангаа тушаадаг, гэвч УБЕГ нь тайлангийн мөрөөр ямар нэгэн дүн шинжилгээ хийдэггүй, арга хэмжээ авдаггүйгээс болж ТББ-ууд жилийн тайлангаа тушаах нь багассан.

**Зураг 1. ТББ-ын тайлан хүлээн авагчийн төрөл**




Сүүлийн 3 жилийн хугацаанд оролцогч байгууллагуудын 88.9% нь тайлан гаргаж, 11.1% нь тайлан гаргаагүй гэж хариулжээ. Нийт тайлан гаргаж буй байгууллагуудын 52.6% нь дэлгэрэнгүй тайлан, 36.3% нь Х тайлан гаргасан байна.

**График 32. Сүүлийн 3 жилд санхүүгийн тайлан гаргасан байдал, байршилаар, хувиар**




Тайлан гаргаагүй буюу санхүүгийн тайланг илгээгээгүй байгууллагуудын хувьд санхүүжилт байхгүй, үйл ажиллагаа явуулаагүй, Х тайлан өгөх ёстой гэж мэдээгүй улмаас санхүүгийн тайлан гаргаагүй байна.

**График 33. Засгийн газрын харьяа байгууллагуудад Х тайлан илгээгээгүй шалтгаан, хувиар**



ТББ-ууд санхүүгийн тайлангаа төрийн байгууллага, удирдах зөвлөл, гишүүд, хандивлагч нартаяа тайлагнадаг байна.

**График 34. Сүүлийн 3 жилд санхүүгийн тайлан гаргасан байдал, хувиар**



Оролцогч талуудын ярилцлагаас хараад тэдний тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг нь татвар, санхүүгийн тайлангаар нь хардаг гэсэн байна. Одоогийн хууль эрхзүйн бичиг баримтад тусгагдсан ТББ-ын тайлангийн төрөл, түүний шалгуур, шаардлага харилцан адилгүй. Дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс үзнэ үү.

#### Шигтгээ 10

...Төрийн байгууллага тайланг хүлээн аваад дүн шинжилгээ хийдэггүй, нэгдсэн тайллагналт байхгүй, тайлангийн ач холбогдлыг харуулсан системгүй байна. ТББ нь нийгмийн даатгалын ерөнхий газарт, улсын бүртгэлийн ерөнхий газарт, татварын албанад, сангийн яаманд гээд албан ёсны 4 төрлийн тайлан өгөх шаардлагатай байна.<sup>37</sup> Хэрэээ гэрээгээр гүйцэтгэсэн бол гэрээт үйл ажиллагааны тайлан энд бас нэмэгдэнэ (ФБЯ - Оролцогч талууд, 2020).

Энэ асуудлыг өмнө нь ч судлаачид хөндөж байжээ. Тухайлбал, ТББ нь олон нийтийн эрх ашгийн төлөө эсхүл гишүүдэд үйлчилдэг аль ч утгаар үйл ажиллагааны тайланг заавал гаргаж байх шаардлагатай. Нэгэнт гаргасан тайланг төрийн эрх бүхий байгууллагад өгөх нь асуудал бус, харин бүх ТББ нь цахим хуудастай байж, түүнийгээ байнга ажиллуулах нь төвөгтэй тул ил тод болгоход хүндрэл үүсдэг. Мөн тайланг хүлээн авсан төрийн байгууллага нь нийтэд ил тод болгох асуудлыг шийдвэрлэвэл энэ нь төрөөс дэмжиж буй нэг хэлбэр гэж үзэж болно (“Баасанжав консалтинг” ХХК, 2017).

## 2.4. ТББ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хүснэгт 12. Иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, хувиар


№	Байгууллагуудын төрөл	Нэлөөллийн үйл ажиллагаа	Үйлчилгээ үзүүлэх	Хамтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх	Тухайн байгууллагад тайлагнах
1	Төрийн	20.9%	13.5%	57.7%	15.4%
2	Олон улсын	7.0%	6.3%	32.5%	5.6%
3	Хөрөнгө оруулалт, санхүүжүүлэгч	5.6%	8.9%	24.0%	7.9%
4	Хувийн хэвшил	9.8%	13.6%	47.6%	4.8%
5	ТББ, сайн дурынхан	13.5%	9.7%	58.1%	4.5%
6	Хэвлэл мэдээлэл	11.9%	4.4%	41.9%	3.5%
7	Их, дээд сургууль, эрдэм шинжилгээ	6.7%	5.4%	36.0%	2.6%

### Шигтгээ 11

-...Төрийн байгууллагатай ТББ хэрхэн ажиллаж байгаа талаар бүлгийн ярилцлагаа хийхэд дараах төрлөөр тодорхойлсон. Нэгт, төрийн бодлого боловсруулахад оролцуулах. Хоёрт, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх. Гуравт, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд төр болон иргэд аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах. Дөрөвт, Төрийн худалдан авалт хийхэд ТББ-ыг оролцуулах. (ФБЯ - Оролцогч талууд, 2020).

Энэ талаар эрхзүйн мэдээллийн нэгдсэн системд “төрийн бус байгууллага” гэх үг орсон хууль 55, ЗГ-ын тушаал, хөтөлбөр, журам 27 байна. Чанарын судалгааны программын дагуу “хамтын ажиллагаа”-ны заалтыг хэр тусгасан байдалд дүн шинжилгээ хийхэд дээрх эрх бүхий байгууллагын чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх хамтын ажиллагааг 12 хуулийн заалт, 54 бичиг баримтад тусгасан байна. Харин хамтран ажиллахын тулд ямар нэгэн шалгуур тавьсан хуулийн заалт 1, тогтоол тушаал журмын заалт 21 байв. Мөн ямар нэгэн үйл ажиллагааг ТББ-ын үүрэгтэй холбож тусгасан хуулийн заалт 43, тогтоол, шийдвэрийн бичиг баримт 2 байна. Үүнээс дүгнэж үзэхэд төр, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах хэв маяг нь төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх хэлбэр зонхицж байна. Ингэхдээ ихэнхи заалт нь олон нийтэд хандсан үйл ажиллагаа, нийтийг соён гэгээрүүлэх, таниулан сурталчлах хэлбэрийн үйл ажиллагааг ТББ-гаар гүйцэтгүүлэхээр заасан байна (Эрхзүйн мэдээллийн нэгдсэн систем).

Зураг 2. Эрхзүйн мэдээллийн нэгдсэн системд “төрийн бус байгууллага” үг орсон бичиг баримтуудын агуулга, хувиар



### **Шигтгээ 12**

-... Хамтын ажиллагааны төрөл хэлбэрийн талаар ярилцлагад оролцсон талуудаас дараах зүйлсийг онцолж байв. ТББ нь ямар салбар, ямар чиглэлээр үйл ажиллагааг явуулах чадавхтай гэх мэдээлэл байхгүй, тиймээс хамтран ажиллахын тулд ОУ-ын болон төрийн байгууллагууд нь өөрсдийнхөө боловсруулсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд л мэдээллийг цуглувалж, тээгэхдээ удирдлага, гүйцэтгэлийн баг болон үйл ажиллагаа явуулж байсан хугацааг нь харгалзан сонгодог гэсэн. (ФБЯ - Оролцогч талууд, 2020).

Харин ТББ-ын төлөөлөлтэй энэ талаарх ярилцлахад төр-иргэний нийгэм, иргэний нийгэм-хувийн хэвшил, болон иргэний нийгэм-ОУ байгууллагын хамтын ажиллагаа нь салбар бүрд л харилцан адилгүй түвшинд байгааг илэрхийлж байв.

МУЗН, зарим үндэсний холбоод нь холбогдох төрийн байгууллагатай бүх түвшинд нягт хамтран ажиллаж байгаа бол бусад ИНБ-үүд нь салбарын хөгжлийн бодлого, хууль эрх зүйн зохицуулалт, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, үйл ажиллагааны түвшинд гээд өргөн хүрээнд хамтарч байгаа ч харилцан хамаарал бүхий байдал харьцангуй сул байна. Харин зарим жижиг, хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагаанд түлхүү чиглэсэн байгууллага нь төрийн байгууллагуудаас харьцангуй хол хөндий үйл ажиллагаа явуулж байгаа нь ажиглагдаа.

ТББ-үүд олон төрийн байгууллагуудтай хамтран ажиллахад тулгардаг нийтлэг бэрхшээл нь хандлага, харилцааны асуудал гэж онцолж байв.

### **Шигтгээ 13**

-...Төрийн байгууллагуудтай хамтарч ажиллахад эрх мэдлийн хувьд ялгаатай. Өөрөөр хэлбэл, төрийн бус гэж шууд утгаар нь хүлээж авдаг. Төрийн байгууллага, яамд маш хаалттай, хүнд сурталттай. Жишээ нь, нэг яамны төрийн нарийн бичгийн дарга “ТББ-үүд та нар ямар ч зардалгүйгээр үйл ажиллагаа явуулах ёстой, сайн дурын хүмүүс учраас та нарт ямар ч үйл ажиллагааны зардал байх ёсгүй” гэж хэлж байсан. (ФБЯ-Оролцогч талууд, 2020)

Хэдийгээр төр-иргэний нийгмийн хамтын ажиллагаа өргөжиж байгаа ч харилцан бие биедээ үл итгэсэн, хүнийрхсэн уур амьсгал хэвээр байна.

### **Шигтгээ 14**

-...Төрийн байгууллагуудын зүгээс төрийн бус байгууллагуудыг бодитой зүйл хийдэггүй гэж ялгаж харьцах явдал маш их байдаг. Төрийн бус байгууллага яагаад хий хоосон цаас явуулаад, хий хоосон зүйл үнэлж хянадаг вэ, бодитой зүйл хиймээр байна, бодитой бус зүйл хийдэг ийм төрийн бус байгууллагуудтай хамтран ажилламааргүй байна гэсэн хандлага төрийн байгууллагаас их гардаг... (ФБЯ-Оролцогч талууд, 2020)

Хамтын ажиллагааны хүрээнд тодорхой асуудал, бэрхшээл байгаа ч хамтын ажиллагааны үр дүнтэй, сайн туршлагууд улам бүр нэмэгдэж байгааг мөн ТББ-ууд хэлж байна. Энэ нь гэхдээ урт хугацааны тогтвортой хамтын ажиллагааны үнэ цэний үндсэн дээр бий болж байна.

#### Шигтгээ 15

...Хүний эрхийн форум, хүний эрхийн байгууллагын форум гэсэн нээлттэй платформ байгаа. Үүнийг манай улсын хуулиар хуулийн этгээд гэж хүлээн зөвлөөрөхгүй гэдэгт итгэж байгаа. Энэ платформуудыг яагаад хүлээн зөвлөөрдөг болсон бэ гэхээр манай платформоос НҮБ руу МУ-д хүний эрхийн асуудал хэрхэн хэрэгжиж байгаа талаар тайлангууд явуулдаг. НҮБ, Женева-аас шалгаад Монгол улсын зөвлөмж црж байгаа. Үүн дээр эхлээд өрөөсөө тоогоогүй, дараа нь шахалтад ороод хэлбэр төдийгүй ажилласан. Өнөөдрийн байдлаар зөвлөмжийг хүлээн зөвлөөрөгдөөд хамтран ажиллаад явж байна. Ерөнхийдөө дуртай биш. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд хүлээн авч, хүлээн зөвлөөрдөг.”...(ФБЯ-Оролцогч талууд, 2020)

Мөн боловсролын салбарт ч үр нөлөөтэй хамтын ажиллагааны сайн жишээний талаар ТББ-ын төлөөлөл ярьсан. Ийм сайн туршлагыг бий болгоход ТББ-ын өөрсдийн чадавхи, нээлттэй байдал зэрэг нь нэн чухал байгаа нь ажиглагдсан.

Үүнээс гадна соёл урлаг, хүүхэд хамгааллын чиглэлээр хувийн хэвшил, ОУБ болон олон нийттэй үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлж байгаа туршлага ч мөн байна.

Төрөөс иргэний нийгмийн байгууллагад үзүүлдэг тусlamж дэмжлэгийг судалгаанд оролцогч ТББ-ууд дараах байдлаар үнэлжээ. Аль ч тусlamж дэмжлэгийн хувьд оролцогчид Муу болон Дунд зэрэг гэсэн үнэлгээг түлхүү сонгосон байна. Эдгээр үнэлгээний дундгийг нийт оролцогчдын тоонд харьцуулахад Дунд зэрэг буюу 3.00 гэсэн үнэлгээнээс бүгд доогуур түвшинд тодорхойлогдсон байна.

Улаанбаатар хотын болон орон нутгийн ТББ-ууд ялгаатай байдлаар үнэлсэн байна.

**Хүснэгт 13. Төрөөс үзүүлдэг тусlamж дэмжлэгт өгч буй дундаж үнэлгээ, / 1-5 онооны шкалаар /**

Төрөөс үзүүлж байгаа тусlamж дэмжлэг	Нийт түүвэрт эзлэх хувь					Нийт оролцогчдын дундаж үнэлгээ
	Маш муу	Муу	Дунд зэрэг	Сайн	Маш сайн	
1 Хууль эрх зүйн орчин	17.3%	29.4%	<b>40.3%</b>	10.5%	2.5%	<b>2.52</b>
2 Санхүүжилт	32.9%	<b>40.3%</b>	18.9%	7.3%	.6%	<b>2.02</b>
3 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх	23.3%	<b>38.1%</b>	23.4%	12.2%	3.1%	<b>2.34</b>
4 Харилцаа хандлага	14.9%	29.0%	<b>35.1%</b>	18.4%	2.5%	<b>2.65</b>
5 Төрийн бодлого шийдвэрт татан оролцуулах	20.1%	<b>35.9%</b>	31.6%	10.7%	1.8%	<b>2.38</b>
6 Үйл ажиллагаа тайлагнах, мэдээлэл солилцох	17.1%	<b>32.1%</b>	31.5%	17.3%	2.0%	<b>2.38</b>

ТББ-ын хувьд судалгаа, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний мониторинг, улсын болон орон нутгийн төсвийн хяналтыг хийхэд төрөөс үзүүлж буй аливаа дэмжлэгийг “Муу” гэж үнэлжээ.

ФБЯ-ын оролцогчидтой төрийн дэмжлэг, оролцооны талаар ярилцсан. Төр зарим тодорхой үйлчилгээнүүдээсээ татгалзаж, чиглэл бүрээр гүйцэтгүүлэх байгууллагаа зарлах, сонгох шалгуураа тодорхой болгох, системчлэх хэрэгтэй. Энэ нь эргээд ТББ-ын

тайлан болон татварын үүрэгтэй холбогдсон байх талаар ОУ-ын зарим жишээг дурьдаж байв. (ФБЯ - Оролцогч талууд, 2020)

Мөн төрийн зүгээс ТББ-ыг бусад гаднын байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх эрхэзүйн харилцааг бий болгох ёстой гэж үзсэн бөгөөд яам болгон дээр байсан Иргэний зөвлөл гэдэг шиг тогтолцоо үүнд их хувь нэмэртэй гэж байв. (ФБЯ - Оролцогч талууд, 2020)

Шүсмээс 16


- ... Мөн тэр засаг солигдоход үйл ажиллагаа нь тогтвортой үргэлжлэх асуудлыг шийдэж өгөөгүй, төрийн талаас хариуцсан хүн нь солигддог (ФБЯ - Оролцогч талууд, 2020).
  - ... Төртэй хамтран ажиллах хүсэл ТББ-д байдаг, нөөц боломжтой хэдий ч, өөрсдийнхөө давуу талыг харуулах, мэдээллээ системтэйгээр хуваалцах боломж тогтолцоо байхгүй, тухайлбал 4 өөр газарт 4 өөр тайлан илгээдэг боловч ач холбогдол нь гардаггүй (ФБЯ - Оролцогч талууд, 2020).

Шигтгээ 17

- ... Үүнтэй холбоотой нэг судалгаанд "ТББ-ын 63.0 хувь нь төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өнөөгийн нөхцөл байдал нь Дунд, 34.0 хувь нь Хангатгүй, 3.0 хувь буюу 1 байгууллага Сайн гэж дүгнэсэн (Төрийн байгуулалтын экспертийн зөвлөл-2020,

Энэхүү судалгаанд оролцсон байгууллагуудын хамтын ажиллагаанд учирдаг саад бэрхшээлийг дараах байдлаар харууллаа. Үүнд бусад хуулийн этгээдүүдтэй хамтран ажиллахад мэдээллийн хүртээмжгүй байдал, хүнд суртал болон хаалттай байдлын асуудал хамгийн ихээр тулгардаг гэжээ. Харин судалгаанд оролцогчдын 10 орчим хувьд нь бусад байгууллагуудтай ажиллахад асуудал үүсдэггүй гэж үзсэн. Орон нутгийн байгууллагуудын хувьд ил тод бус байдал болон хүн хүч, санхүүгийн нөөц, чадавхи хүрэлцээгүй байдаг нь хамтын ажиллагаанд хундрэл учруулдаг хэмээн онцолжээ.

### График 35. Хамтын ажиллагаанд үүсдэг бэрхшээл, хувиар



ТББ-ын төрлөөр нь авч үзвэл, нийгэмд үйлчилдэг байгууллагад тулгамддаг хамтын ажиллагааны бэрхшээл ихэнх үзүүлэлтээрээ гишүүддээ үйлчилдэг байгууллагаас их байна.

**График 36. Хамтын ажиллагаанд учирдаг саад бэрхшээл, үйл ажиллагааны хэлбэрээр**




Хамтын ажиллагааны бэрхшээлийн талаарх дээрхтэй ижил асуудлуудыг өөр нэг судалгааны тайланд бас жагсаасан байдаг (Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа, 2020). Тухайлбал:

- Салбар дундын хамтын ажиллагаа дутмаг;
  - Төрийн байгууллагын тогтвортой үргэлжлэхгүй буюу нэг удаагийн болон албан тушаалтны хандлагаар хэрэгжих гэх мэт асуудлыг хөндсөн;
  - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын үйл ажиллагаа, чадавхийг үнэлдэггүй бөгөөд бага зардлаар их зүйл хийлгэх гэсэн нь нэг хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг үүсгэдэг;
  - Төрийн байгууллагаас багахан төсвийн хүрээнд амьдралд нийцэхгүй шаардлага тавьж, өндөр үр дүн нэхэх нь байгууллага, иргэдийг шантраах, дахин санал хүсэлт тавих сонирхол хүслийг хаасан явдал их болохыг;
  - Төрийн байгууллагаас гаргах тайлан дүгнэлтэд тоог чухалчилсан, бодит амьдралд нийцэхгүй статистик гаргах явдал их байх;
  - Төрийн байгууллага хүний нөөцийн хязгаарлагдмал нөхцөл байдлаа хүлээн зөвшөөрч, ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх тогтолцоог боловсронгуй болгож, асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэжээ.


Энэхүү судалгаанд оролцсон 10 байгууллага тутмын 9-д нь бусад байгууллагуудтай хамтран ажиллахад ямар нэгэн саад бэрхшээл тулгардаг гэсэн ба эдгээр асуудлуудыг дараах арга замаар шийдвэрлэдэг байна. Харин асуудал үүссэн ч ямар нэгэн арга хэмжээ авдаггүй ТББ-үүд 40 орчим хувийг эзэлж байна.

*График 37. Хамтын ажиллагаанд үүсдэг асуудлыг шийдвэрлэх арга зам*




Арга хэмжээ авдаггүй гэж хариулсан /n=231/ байгууллагуудын тал орчим хувь нь ямар арга хэмжээ авахаа мэдэхгүй байсан бол үлдсэн хэсэг нь залхсан, нэмэргүй гэж бодсон, халширан, хүн хүч, нөөц чадавхи хүрэлцээгүй, мөн ямар нэгэн дарамт шахалтаас болгоомжилсон гэж тус тус хариулжээ.

**График 38. Арга хэмжээ авдаггүй шалтгаан, байгууллагын төрлөөр, хувиар**



Энэ үзүүлэлтийг хот хөдөөгийн байршилаар харахад орон нутгийн ТББ нь хүн хүч, чадавхи хүрэлцээгүйн улмаас арга хэмжээ авч чадаагүй гэсэн шалтгаан нь Улаанбаатар хотын ТББ-уудаас 2 дахин илүү хувийг эзэлж байна.

**График 39. Арга хэмжээ авдаггүй шалтгаан, байршилаар, хувиар**




### БҮЛЭГ 3. ТББ-ЫН ҮР НӨЛӨӨ

Судалгаанд хамрагдсан ИНБ-уудын үйл ажиллагааны зорилтот бүлгийг Хавсралт 1-д харуулж байна. Эдгээр байгууллагуудын ихэнх хувь нь дараах зорилтот бүлэг буюу иргэд, олон нийт, залуучууд, хүүхдүүд, эмэгтэйчүүд, гэр бүлд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байна. Цаашид ТОП-5 зорилтот бүлэгт үйл ажиллагааны чиглэл болон хэлбэрийг харьцуулж үр дүнг харуулна.

Судалгаанд оролцсон байгууллагуудын зорилтот бүлэгт чиглэгддэг үйл ажиллагааны чиглэлийг авч үзье. Үүнд дээрх ангилалд ороогүй бусад үйл ажиллагаанд салбарын ажилчдын эрх ашгийг хамгаалах, салбарын хөгжил, хяналт бодлого, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах, ахмад өндөр настанд чиглэх, хүний эрх, иргэдийн оролцоо, эмэгтэйчүүдийн эрх ашиг, үндэсний өв соёлын хадгалах, хууль зүйн зөвлөгөө өгөх зэрэг чиглэл багтаж байна.

**График 40. Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны зорилтот бүлэг, хувиар**



Үйл ажиллагаа явуулж буй ихэнх ашгийн төлөө бус байгууллагын хувьд иргэд, олон нийт, залуучууд, хүүхдүүд, эмэгтэйчүүд, гэр бүлд сургалт, судалгаа, зөвлөгөө, тусlamж үйлчилгээ, нөлөөллийн ажлыг илүүтэй хийж байна.

**Хүснэгт 14. ТББ-ын зорилтот бүлэг, үйл ажиллагааны хэлбэрээр /олон сонголттой хариултаар/**

№	Үйл ажиллагааны хэлбэр	Иргэд, олон нийт	Залуучууд	Хүүхдүүд	Эмэгтэйчүүд	Гэр бүл
1	Сургалт	70.1%	83.6%	81.6%	82.1%	76.2%
2	Зөвлөгөө	56.0%	63.8%	50.5%	68.7%	69.9%
3	Тусlamж үйлчилгээ	38.8%	48.4%	44.7%	55.3%	63.6%
4	Судалгаа	45.5%	47.9%	44.2%	57.0%	55.9%
5	Нөлөөлөл	42.4%	47.4%	38.9%	55.3%	52.4%
6	Мэдээллийн үйлчилгээ	44.2%	48.4%	37.9%	52.0%	51.7%
7	Сурталчилгаа	26.1%	26.8%	24.2%	29.6%	27.3%
8	Өмгөөлөл	10.5%	12.7%	7.9%	14.5%	18.2%
9	Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний мониторинг	10.1%	10.8%	9.5%	16.2%	9.8%
10	Улсын болон орон нутгийн төсвийн хяналт	4.4%	6.1%	4.7%	7.8%	5.6%
11	Бусад	1.2%	1.4%	1.6%	1.1%	1.4%

ТББ-ын нийтэд чиглэсэн үйл ажиллагааны цар хүрээг сүүлийн 3 жилийн хугацаанд дараах байдлаар тодорхойлжээ.


**Хүснэгт 15. Үр нөлөө, байршилаар**

№	Үр нөлөө	Улаанбаатар	Орон нутаг
1	ТББ-ын үйл ажиллагаа, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	554,878	229,852
2	Хэвлэн нийтлүүлсэн ном, товхимол, гарын авлагын тоо	46,762	9,726
3	Эрхлэн гүйцэтгэсэн судалгааны тоо	7,256	1,997
4	Байгаль орчны байгууллагын хувьд үйл ажиллагаанд хамрагдсан газар нутаг, гол горхи, биологийн болон амьтны төрөл зүйл	2,787	1,076
5	Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжилсэн тохиолдол	2,612	394
6	Орон нутаг болон үндэсний хэмжээний бодлогын баримт бичиг, эрх зүйн актад оруулж батлуулсан нэмэлт өөрчлөлтийн тоо	402	175
7	Бусад	1,694	60

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо сүүлийн 3 жилд 784,730, тэдний хэвлэн нийтлүүлсэн ном, товхимол, гарын авлагын тоо 56,524-д хүрчээ.

Доорх графикуудад сүүлийн 3 жилд гаргасан үр нөлөөг ТОП-8 үйл ажиллагааны чиглэлээр ангилж харууллаа.

**График 41. Орон нутаг болон үндэсний хэмжээний бодлогын баримт бичиг, эрх зүйн актад оруулж батлуулсан нэмэлт өөрчлөлтийн тоо, үйл ажиллагааны чиглэлээр**



**График 42. ТББ-ын үйл ажиллагаа, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үйл ажиллагааны чиглэлээр**



**График 43. Нийтийн эрх ашигийг төлөөлөн нэхэмжилсэн тохиолдол, үйл ажиллагааны чиглэлээр**



**График 44. Эрхлэн гүйцэтгэсэн судалгааны тоо, үйл ажиллагааны чиглэлээр**



**График 45. Хэвлэн нийтлүүлсэн ном, төвхимол, гарын аяллагын тоо, үйл ажиллагааны чиглэлээр**



**График 46. Байгаль орчны байгууллагын хувьд үйл ажиллагаанд хамрагдсан газар, нутаг, гол горхи, биологийн болон амьтны төрөл зүйл, үйл ажиллагааны чиглэлээр**



**График 47. Өөрчлөлт оруулсан бусад үйл ажиллагаа, үйл ажиллагааны чиглэлээр**



Үндэсний/орон нутгийн хөтөлбөрт өөрчлөлт оруулсан, шинээр хөтөлбөр батлуулсан болон хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулсан байдлыг харахад орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд илүү оролцоотой байжээ.

**График 48. Хууль тогтоомж, бодлого хөтөлбөрт өөрчлөлт оруулсан байдал, байршилаар, хувиар**



ТББ-ын үр нөлөөг хэмжих ба илэрхийлэх шалгуур нь эрхзүйн хувьд ч, мэдээллийн хувьд тодорхой бус байна. Оролцогч талуудын бүлгийн ярилцлагаар хэд хэдэн оролцогчид төрийн бус байгууллагын үр нөлөө нийгэмд ил тод, хэмжигдэхүйц биш байгаа гэдэгтэй санал нэгдэж байсан юм. Тэд хэдийгээр маш их зүйлийг гүйцэтгэдэг боловч эргээд мэдээлэх, өөрөөр хэлбэл тайлагнах тогтолцоо сайн бүрдээгүй, төрийн байгууллагуудад өгдөг тайланд нь ямар ч урамшуулал дэмжлэг, эсвэл үнэлгээний механизм байхгүй. Харин ОУ-ын байгууллагын төлөөлөл хамтран ажиллаж байгаа ТББ-уудынхаа үр нөлөөг гэрээгээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнгээр хэмждэг гэсэн (ФБЯ - Оролцогч талууд, 2020).

Оролцогчид үр нөлөөг нь үнэлдэг сайн тогтолцооны гол зорилго нь татварын хөнгөлөлт, урамшуулал, мөн төрөөс үзүүлэх дэмжлэг, авах санхүүжилт, эргээд сайн, муу гэж эрэмбэлэгдэх ил тод үнэлгээтэй шууд холбогдох ёстой гэж онцолсон.

Нийтэд чиглэсэн үйл ажиллагааны хувьд бусад буюу байгаль орчин хамгаалах, иргэд олон нийтэд чиглэсэн сургалт зөвлөгөө, соён гэгээрүүлэх зэрэг ажлуудыг дараах графикт харууллаа.


**График 49. Үйл ажиллагааны чиглэл, бусад**



Нийт байгууллагуудын 46.9% нь өөрсдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа үнэлдэг тогтолцоотой бол үлдсэн 53.1% нь үйл ажиллагаагаа үнэлдэггүй аж.


Хууль тогтоомж, бодлого хөтөлбөрт өөрчлөлт оруулсан байгууллагуудын 27.8% нь үндэсний/орон нутгийн хөтөлбөрт, 25.2% нь бодлогын баримт бичигт, 22.0% нь хууль, хуулийн заалтад өөрчлөлт оруулжээ. Бусад буюу байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулсан, төрөөс хэрэгжүүлж буй ажилд оролцсон зэрэг ажил үйлчилгээг үзүүлсэн байна.

**График 50. Хууль тогтоомж, бодлого хөтөлбөрт өөрчлөлт оруулсан байдал, хувиар**



Мөн төрийн болон нийтийн үйлчилгээг хэрэгжүүлэх механизмд өөрчлөлт оруулсан байдлыг авч үзвэл 30.5% нь үйлчилгээний хамрах хүрээ, хүртээмжийг сайжруулсан, 28.0% үйлчилгээ хүргэх үйл явц, чанар ахиц гаргасан, 21.3% нь үйлчилгээний тогтолцоог өөрчилсөн зэрэг өөрчлөлтүүдийг хийжээ.

**График 51. Төрийн болон нийтийн үйлчилгээг хэрэгжүүлэх механизмд өөрчлөлт оруулсан байдал, хувиар**




Харин төрийн байгууллагын ил тод, хариуцлагатай байдал болон авлигатай тэмцэхэд өөрчлөлт оруулсан байдлын харахад 28.1% нь хариуцлагатай байдлыг сайжруулсан, 25.5% ил тод байдлыг сайжруулсан, 8.6% нь авлигатай тэмцэхэд хувь нэмрээ оруулжээ.

**График 52. Төрийн байгууллагын ил тод, хариуцлагатай байдал болон аслигатай тэмцэхэд өөрчлөлт оруулсан эсэх, хувиар**



Ашгийн төлөө бус байгууллагуудын 78.3% нь зорилтот бүлгийн олон нийтийн оролцоог дээшлүүлсэн, 77.7% нь зорилтот бүлгийн олон нийтийн хандлага, ойлголтыг дээшлүүлсэн зэрэг өөрчлөлтүүдийг хийв.

**График 53. Иргэд, олон нийтийн оролцоонд өөрчлөлт гаргасан эсэх, хувиар**



Хувь хүн, байгаль орчин, амьтан ургамлын зүй зохистой байдалд өөрчлөлт оруулсан байдлаар нь авч үзвэл 58.3% нь хувь хүн, өрхийн амьдрал эерэг өөрчлөлт гаргасан, 38.1% нь байгалийн нөхөн сэргээлт хийлгэсэн, 30.5% нь ургамал амьтны зүйл аварсан, хамгаалсан зэрэг өөрчлөлтүүдийг гаргажээ.

**График 54. Хувь хүн, байгаль орчин, амьтан ургамлын зүй зохистой байдалд өөрчлөлт гаргасан эсэх, хувиар**



Иргэний нийгмийн байгууллагуудын хувьд өөрсдийн байгууллагын хамгийн үр нөлөөтэй, баходраг сайн жишээг дараах байдлаар дурджээ. Дараах графикт ТОП 10 жишээг харууллаа.

График 55. Байгууллагын үр нөлөөтэй, баходраг сайн жишээ, хувцас



## БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ ОРОН ЗАЙ

### 4.1. ИРГЭНИЙ СУУРЬ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Иргэний орон зайнт үнэлгээд иргэний суурь эрхийн хэрэгжилт, түүнчлэн ТББ-ын эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг үнэлүүлэв.

Иргэний суурь эрх, эрх чөлөөний хүрээнд таван асуудлыг үнэлүүлэхэд нийт дундаж индекс нь 3.03 гарав. Энэ нь иргэний суурь эрхийн хэрэгжилт хангалтгүй байна гэсэн үг юм.


*Хүснэгт 16 Иргэний суурь эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд ТББ-уудын өгсөн үнэлгээ*

Иргэдийн суурь эрх, эрх чөлөөний байдал	Нийт түүвэрт эзлэх хувь					Нийт оролцогчдын дундаж үнэлгээ
	Маш мую	Муу	Дунд зэрэг	Сайн	Маш сайн	
1 Мэдээлэл хүлээж авах, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх	4.4%	16.3%	38.5%	32.1%	8.8%	<b>3.25</b>
2 Тайван жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах	7.5%	17.1%	35.3%	33.7%	6.4%	<b>3.14</b>
3 Иргэдийн оролцоо, иргэдийн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах	6.9%	22.8%	37.3%	27.7%	5.3%	<b>3.02</b>
4 Үл ялгарварлан гадуурхах, тэгш хамруулах	8.8%	25.0%	37.5%	25.3%	3.4%	<b>2.89</b>
5 Хүний эрх / хууль дээдлэх	10.0%	24.3%	38.4%	23.7%	3.7%	<b>2.87</b>

Хамгийн Муу үнэлгээтэй буюу хамгийн их зөрчигдөж байгаа нь хууль дээдлэх ёс болон, ялгарварлан гадуурхалтаас ангид байх эрх байна.

- Мэдээлэл хүлээн авах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нийт оролцогч байгууллагын 59.2% буюу ихэнх нь Дундаас доош, Муу эсвэл Маш мую гэж үнэлсэн байна.
- Иргэдийн мэдээлэл хүлээн авах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нийт оролцогч байгууллагууд Дунд зэрэг буюу 3 оноогоор үнэлжээ. Харин хөдөө орон нутгийн нийгэмд болон гишүүдэд үйчилдэг ТББ-уудын хувьд 4 оноогоор үнэлсэн байна.
- Иргэдийн тайван жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах эрхэд 59.9% нь Дунд болон түүнээс доош үнэлгээ өгсөн байна. Дундаж үнэлгээ 3.14 буюу Дунд зэрэг үнэлгээтэй байна.
- Иргэдийн оролцоо, иргэдийн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах эрхийг нийт оролцогч байгууллагуудын 67.0% нь Дунд болон түүнээс доош гэж үнэлжээ. Дундаж үнэлгээ 3.02 оноотой байна.
- Мөн судалгаанд оролцогчдын төлөөллөөс дийлэнх хувь нь үл ялгарварлан гадуурхах, тэгш хамруулах эрхэд Дундаас доогуур үнэлгээ өгчээ. Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас хүний эрх, хууль дээдлэх байдалд талаас илүү хувь нь Дундаас доогуур үнэлгээ өгчээ.

**График 56. Эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, байршилаар, хувиар**



Дээрх графикаас харахад охид эмэгтэйчүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг гишүүнчлэлтэй байгууллага нь зорилтот бүлгийн эрхийг хамгаалахад хангалттай түвшинд ажилладаг байна. Харин малчид болон шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах чиглэлээр хангалттай ажиллаж чаддаггүй гэж хариулжээ.

#### 4.2. ИНБ-ЫН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ ТББ-ЫН ҮНЭЛГЭЭ

Харин ИНБ-ын эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг нийт 8 асуultaар хэмжиж үзэхэд дунд зэрэг буюу 3.12 гэсэн дундаж үзүүлэлттэй гарав.

**Хүснэгт 17. ИНБ-ын эрх, эрх чөлөөний байдал, төрлөөр**

	Иргэний нийгмийн байгууллагын эрх, эрх чөлөөний байдал	Нийт түүвэрт эзлэх хувь					Нийт оролцогчдын дундаж үнэлгээ
		Машмуу	Муу	Дунд зэрэг	Сайн	Маш сайн	
1	Мэдээлэл хайх, хүлээн авах эрх чөлөө	4.8%	15.1%	34.8%	39.4%	5.9%	3.26
2	Хэвлэл мэдээлэл ашиглах эрх чөлөө	2.9%	12.0%	27.7%	48.5%	8.9%	3.48
3	Цахим сүлжээ ашиглах эрх	1.2%	5.4%	18.2%	56.5%	18.7%	3.86
4	Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө	2.8%	10.2%	31.3%	47.1%	8.5%	3.48
5	Эвсэл холбоо байгуулан нэгдэх эрх	2.9%	9.5%	30.0%	46.9%	10.7%	3.53
6	Иргэний нийгмийн байгууллагууд засгийн газраас ангиid бие даан ажиллах эрх	5.0%	20.2%	39.2%	30.3%	5.3%	3.11
7	Иргэний нийгмийн байгууллагуудын төсвийн таатай орчин	14.5%	38.1%	34.0%	12.0%	1.5%	2.48
8	Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг засгийн газар дэмждэг эсэх	17.3%	41.6%	29.4%	10.2%	1.5%	2.37

<b>9</b>	Засгийн газар нь иргэдийн саналыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэдэг хууль ёсны үүрэг агентуудтай	12.0%	36.7%	37.9%	11.9%	1.5%	2.54
----------	---	-------	-------	-------	-------	------	------

Төрөөс ИНБ-д үзүүлэх дэмжлэг, ИНБ-ын төсвийн орчин, төрөөс иргэдийн саналыг хүлээн зөвшөөрөх байдал зэрэг нь хамгийн Муу буюу дундаас доогуур үнэлгээтэй байна. Харин хамгийн сайн хэрэгжилттэй эрх нь Цахим сүлжээ ашиглах эрх байна.

ТББ-ын мэдээлэл хайх, хүлээн авах эрх чөлөөг 54.7% нь дундаас доогуур, хэвлэл мэдээлэл ашиглах эрхийг 57.4% нь сайн болон түүнээс дээш, цахим сүлжээ ашиглах эрхийг 75.2% нь сайн болон түүнээс дээш үнэлсэн байна.


Мэдээллийн ил тод байдал ба мэдээллийн эрхийн тухай хуулийг ашигладаг, мэдээлэл авдаг гэх байгууллагууд нь орон нутгаас 67.8%, Улаанбаатар хотоос 48.0% нь байна.

*График 57. Мэдээллийн ил тод байдал ба мэдээллийн эрхийн тухай хуулийг ашигладаг эсэх, байршилаар, хувиар*




Мэдээлэл авч чаддаггүй шалтгаанд Улаанбаатар хотын оролцогч байгууллагуудын хувьд нууц мэдээлэл гээд өгдөггүй, олон шат дамжлагатай байдаг гэх зэрэг давамгайлж байгаа бол орон нутагт хүссэн мэдээллийг өгдөггүй, улсын нууц, огт хариу өгөхгүй байх зэргийг сонгосон байна.

*График 58. Мэдээлэл авч чаддаггүй шалтгаан, байршилаар, тоогоор*




Мэдээлэл авч чаддаггүй шалтгаанаа ТББ-ууд дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд олон шат дамжлага шаарддаг, шаардсан мэдээллийг биш ерөнхий мэдээллийг өгдөг шалтгаан 50.0-аас илүү хувийг эзэлж байна.

*График 59. Мэдээлэл авч чаддаггүй шалтгаан, байгууллагын төрлөөр, хувиар*




Судалгаанд оролцогч байгууллагуудын 58.3% нь төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг шүүмжлэхэд бэрхшээл гардаггүй гэжээ. Дараах графикт гарах саад бэрхшээлийг Улаанбаатар хотын болон орон нутгийн ТББ-уудаар харууллаа.

*График 60. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг шүүмжлэхэд гардаг бэрхшээл, хувиар*



*График 61. Интернэтээр үзэл бодлоо илэрхийлэхэд хориг хязгаарлалт байdag эсэх, хувиар*



Интернэтээр үзэл бодлоо илэрхийлэхэд хориг хязгаарлалт байdag эсэхийг тодруулахад 13.6% нь тодорхой хязгаарлалт байdag гэж үзжээ. Үүний 9.4% Улаанбаатарт, 4.2% нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага байна.

Судалгаанд оролцсон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийн ихэнх нь сургалт, зөвлөгөө хэлбэрээр үйл ажиллагаа явуулж, интернэтээр үзэл бодлоо илэрхийлэхэд тодорхой хэмжээний хязгаарлалт байdag гэсэн байна.

Улаанбаатар хотын 18.4% нь, хөдөөгийн 16.9% нь хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа явуулахад ямарваа нэг саад бэрхшээл тулгардаг гэж үзжээ. Түүнчлэн нийгэмд үйлчилдэг байгууллагын 10.0%, гишүүдэд үйлчилдэг байгууллагын 2.3%, нийгэмд болон гишүүдэд үйлчилдэг байгууллагын 5.1% нь тодорхой бэрхшээлтэй тулгардаг байна.


Аливаа нэг үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа явуулахад саад бэрхшээл илүү учирдаг гэдгийг судалж үзвэл сургалт, судалгаа, нөлөөлөл, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ зэрэг эхний байруудад байна.

*График 62. Хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа явуулахад саад бэрхшээл гардаг байдал, үйл ажиллагааны хэлбэрээр, тоогоор*



Мөн хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа явуулахад ТББ-д үнэ төлбөрийн саад бэрхшээл тулгардаг тул бэрхшээлтэй, хязгаарлалттай байдгийг онцолж байна.

*График 63. Хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа явуулахад саад бэрхшээл гардаг байдал, байршилаар*



Иргэд, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг хэвлэл мэдээллээр явуулахад илүү саадтай учирч байна.


**График 64. Хэвлэл мэдээллээр үйл ажиллагаа явуулахад саад бэрхшээл гардаг байдал, зорилтот бүлгээр, тоогоор**



Иргэд мэдээлэл авах, мэдээллийн ил тод байдлын үзүүлэлт нь өмнөх жилүүдээс дээрдээгүй байна. Тухайлбал, 2012 онд төрийн үйлчилгээний вэб сайтуудын мэдээлэл шинэчлэгддэггүй, хоцрогдсон, тодруулбал иргэдэд хамгийн ил тод байх ёстой төсөв, тендерийн, шалгаруулалт зэргийн талаар хангалтгүй гэж байна гэж дүгнэсэн байна (IRIM судалгааны хүрээлэн, 2012). Мөн тус судалгаанд мэдээллийн найдвартай байдал нь хангалтгүй, буюу вэбсайтын мэдээлэл хэрэглэгч, иргэдэд хүрэхдээ ямар нэг эх сурвалжгүй буюу найдваргүй байдлаар хүрч байна. Ялангуяа төсөв, санхүүгийн мэдээлэл үг үзүүлэлтээр хангалтгүй гарч байна (IRIM судалгааны хүрээлэн, 2012).

Судалгаанд оролцсон нийт байгууллагуудын 7.2% буюу 49 байгууллага нь эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулахад төрийн зүгээс ямар нэг саад бэрхшээл байдаг гэсэн байна. Үүнээс Улаанбаатар хотын 6.3%, орон нутгийн 9.6% нь тийм гэж хариулжээ.

**График 65. Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулахад бэрхшээл учирдаг эсэх, хувиар**




Эдгээр байгууллагуудын 6.1% нь нийгэмд үйлчилдэг, 9.0% нь гишүүдэд үйлчилдэг бол 8.3% нь нийгэмд болон гишүүдэд үйлчилж байна.

Байгууллагын үйл ажиллагааны хэлбэрээр авч үзвэл сургалт, мэдээллийн үйлчилгээ, нөлөөлөл, зөвлөгөө, тусlamж үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд эвлэлдэн нэгдэх,

байгууллага байгуулахад илүү бэрхшээлтэй тулгарч байна.

Доорх графикаас харахад орон нутгийн байгууллагуудад тулгардаг бэрхшээл нь хотод үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас илүү байна. Ялангуяа хүнд суртал гаргах үйл явц хамгийн өндөр буюу 44.0%-тай байна.

**График 66. Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулахад учрах саад бэрхшээлийн төрлүүд, байршилаар, хувиар**



Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулахад бүртгэхээс шалтгаангүй татгалзсан болон авлига шаардсан төрлийн бэрхшээл нийтлэг тулгарчээ.

**Хүснэгт 18. Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулахад учрах саад бэрхшээлийн төрөл, зорилтот бүлгээр, хувиар**




Эдгээр саад бэрхшээлээс хүнд суртал гаргах явдал илүү хувийг эзэлж байна.

Иргэний эрх чөлөө, оролцоог хязгаарлах, хуулийг үл дээдлэх үйл явцыг даван туулахын тулд 16.4% нь иргэний нийгэм бусад этгээдтэй хамтран олон талын оролцогчидтой стратеги боловсруулсан байна.

ТББ-уудын 64.9% нь төрийн зүгээс дарамт шахалт байдаггүй гэсэн байна. Аливаа нэг дарамт шахалтын төрлийг доорх графикт харууллаа.

График 67. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зарласан эсэх, хувиар




Иргэний нийгмийн байгууллагын эрх, эрх чөлөөний байдалд өгсэн үнэлгээг дараах графикт харууллаа. Талаас илүү хувь нь дундаас доогуур үнэлгээг өгчээ.

Иргэний нийгмийн байгууллагудын үйл ажиллагааг Засгийн газар дэмждэг эсэхэд болон Засгийн газар нь иргэдийн саналыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэдэг хууль ёсны үүрэг хүлээсэн байдал ТББ-уудын төлөөлөл дундаас доогуур үнэлгээ өгчээ. Доорх графикт орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд Улаанбаатарын байгууллагуудыг бодвол арай өндөр оноогоор үнэлсэн харагдаж байна. Иргэдийн оролцоог зохицуулсан гол хуулийн заалтууд давхацсан, хоорондоо уялдаа холбоо муу байна. Тухайлбал, санал авч болно гэсэн хуулийн заалттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

ТББ-үүд Засгийн газраас ангид, бие даан ажиллах эрх болон төсвийн таатай орчинд ихэнх хувийг дундаас доогуур үнэлгээ хамарч байна. Нийгэмд үйлчилдэг орон нутгийн ТББ-үүд нь Засгийн газраас ангид, бие даан ажиллах эрхэд муу үнэлгээг, төсвийн таатай орчинд мөн муу үнэлгээг өгч байна.

График 68. Хууль дээдлэх, хүний эрх хамгаалсны төлөө саад бэрхшээлтэй учирсан эсэх, хувиар




Хууль дээдлэх ёс, хүний эрх хамгаалсны төлөө 17.6% нь буюу 120 ТББ саад бэрхшээлтэй учирдаг гэж хариулсан байна.

Нийтлэг тохиолддог саад бэрхшээлийг дараах графикт үзүүллээ.

Хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нь хууль дээдлэх, хүний эрх хамгаалсны төлөө төрийн алба хаагчдаас тавих саад бэрхшээлтэй тулгардаг гэж харагдаж байна.

**График 69. Хууль дээдлэх ёс, хүний эрх хамгаалсны төлөө учрах саад бэрхшээл, хувиар**




Төрийн зүгээс олон төрлийн тайлан мэдээ шаардах, үйл ажиллагааг шууд бусаар хориглосон шийдвэр гаргах, шаардлагагүй хяналт тавих зэрэг дарамт шахалт ихээхэн байдаг байна.

**График 70. Төрийн зүгээс үзүүлэх дарамт шахалт, хувиар**




**График 71. Хууль шүүхийн байгууллагад хандсан эсэх, хувиар**



Түүнчлэн 16.3% нь төрийн байгууллагатай хамтран ажиллахад гарсан саад бэрхшээлийг олон нийтэд ил тод илэрхийлж байсан бөгөөд үүнээс 13.8% нь хууль шүүхийн байгууллагад ханджээ.

**График 72. Хууль шүүхийн байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлсэн эсэх, хувиар**



Хууль шүүхийн байгууллагад хандсан ашгийн төлөө бус байгууллагуудын 53.2% нь асуудлаа шийдвэрлүүлсэн, 39.4% нь шийдвэрлүүлж чадаагүй байна. Үлдсэн хувь нь буруу шийдвэр гарсан, дутуу шийдвэрлэсэн, хүлээгдэж байгаа гэжээ.

#### 4.3. ТББ-ын талаарх иргэдийн санаа бодол


“ТББ-ын талаарх иргэдийн санаа бодлыг тандах судалгаа”-ны үр дүнг энэхүү хэсгээр харуулж байна. Тус судалгаанд нийт 100 иргэн хамрагдсан бөгөөд иргэний нийгмийн байгууллагын талаарх ойлголт, мэдээ мэдээлэл болон үйл ажиллагааны талаарх санаа бодлыг тодорхойлох зорилготойгоор хийсэн. Иргэдийн санаа бодлыг тандах судалгаанд хамрагдсан 10 иргэн тутмын 6 нь эмэгтэй, 4 нь эрэгтэй байлаа. Насны бүлгийн хувьд судалгаанд хамрагдсан оролцогчдыг харахад 30-39 насныхан түлхүү хамрагдсан бол удахааар нь 40-49 насныхан хамрагдсан байна. Харин хамгийн бага хамрагдсан бүлэг нь 60-аас дээш насныхан байлаа. Харин боловсролын түвшний хувьд тал хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байгаа бол үлдсэн хэсэг нь бусад боловсролын түвшинтэй иргэд байв. Мөн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харахад 10 иргэн тутмын 4 нь хувийн байгууллагад, 2 нь ажилгүй иргэд, 2 нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, үлдсэн хэсэг нь бусад ангилалд багтаж байна.

**Хүснэгт 19. ТББ-ын үйл ажиллагаа нийгэм болон иргэдэд ач тустайг үнэлэхэд нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн нэлөө**

Судалгаанд оролцогчийн нас %	Хувь	Тоо
20-29 нас	20.0%	20
30-39 нас	33.0%	33
40-49 нас	26.0%	26
50-59 нас	12.0%	12
60-с дээш	9.0%	9
Оролцогчийн хүйс %		
Эрэгтэй	42.0%	42
Эмэгтэй	58.0%	58
Боловсролын түвшин %		
Бүрэн дунд	55.0%	55
Тусгай дунд	11.0%	11
Бакалавр, түүнээс дээш	34.0%	34
Ажил эрхлэлтийн байдал %		
Төрийн байгууллага	13.0%	13
Хувийн байгууллага	35.0%	35
ОУ-ын байгууллага	0.0%	-
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	15.0%	15
Оюутан	1.0%	1
Тэтгэвэрт	13.0%	13
Ажилгүй	21.0%	21
Групп	2.0%	2


Иргэдийн дийлэнх хувь нь ТББ-ыг иргэд дуу хоолойгоо нэгтгэж, өөрсдийн итгэл үнэмшил дээр суурилан эвлэлдэн нэгдэх гэж байгуулагддаг гэж үзэж байна. Харин төрийг хянах гэж байгуулагддаг гэдэгт иргэд төдийлөн санаа нэгдэхгүй байна.

*График 73. Иргэдийн хувьд ТББ байгуулдаг шалтгаан*




Дээрх үзүүлэлтийг хүйсийн хувьд задлан хараад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү хүний эрхийг хамгаалах гэж, төрийг хянах гэж ТББ байгуулагддаг гэж үзжээ.

*График 74. Иргэдийн хувьд ТББ байгуулдаг шалтгаан, хүйсээр*



Мөн насны хувьд хараад 30-39 насныхан хүний эрхийг хамгаалах гэж, 60-аас дээш насныхан төрийг хянах гэж иргэний нийгмийн байгууллага байгуулагддаг гэж үзсэн бол үлдсэн хэсэг нь дуу хоолойгоо нэгтгэх, эвлэлдэн нэгдэх гэж байгуулагддаг гэжээ.

*График 75. Иргэдийн хувьд ТББ байгуулдаг шалтгаан, насаар*




Иргэд ТББ-ыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалж тэмцдэг, олон нийт, эмзэг бүлэгт тусламж, үйлчилгээ үзүүлдэг мөн шударга бус, тэгш бусын эсрэг жагсаж тэмцдэг ажлуудыг хийдэг гэжээ.

**График 76. ТББ-ын хийдэг ажил, иргэдийн хувьд**




Иргэд ТББ-ын санхүүжилтийг олон улс, гадаадын тусlamж дэмжлэг, иргэдийн болон хувийн хэвшлийн хандив тусlamжаар санхүүжилтээ бүрдүүлдэг гэж үзжээ.

**График 77. ТББ-ын санхүүжилт, оролцогчдын хувьд**




Иргэдийн үзэж буйгаар 30 орчим хувь нь ТББ-ыг нийгмийн асуудлаар төрд нөлөөлж чаддаг, шийдвэр гаргахад ч нөлөөлдөг гэж үзсэн бол 40 орчим хувь нь төрд нөлөөлдөг хэдий ч хүчгүйддэг, 30 орчим хувь нь нөлөөлж чаддаггүй гэж тус тус хариулжээ.

**График 78. ТББ нийгэмд тулгамдсан асуудлын талаар төрд нөлөөлж чаддаг эсэх, хувиар**



Иргэдийн 60 орчим хувь нь ТББ-д асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий хүмүүс ажилладаг гэж боддог бол иргэдийн тал орчим хувь нь сайн дурынхан ажилладаг гэж дүгнэжээ.

**График 79. ТББ нийгэмд тулгамдсан асуудлын талаар төрд нөлөөлж чаддаг эсэх, хувиар**



Иргэдийн хувьд ТББ-ын нийгэмд үзүүлж буй ач холбогдлын түвшнийг эрэмбэлэхэд хамгийн ач холбогдолтойг иргэний орон зайл хамгаалдаг гэсэн бол хамгийн бага ач холбогдолтойг эдийн засагт ач тустай гэж үзжээ.

**Хүснэгт 20. Төрийн бус байгууллагын нийгэмд үзүүлж буй ач холбогдол, хувиар**

I эрэмбэ	Иргэний орон зайл хамгаалахад (хүний суурь эрх, эрх чөлөө, мэдээлэл авах, түгээх эрх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх гэх мэт)
II эрэмбэ	Нийгэм, хүмүүнлэгийн ач тустай (олон нийт, эмзэг бүлгийн халамж, хамгаалал, үйлчилгээ)
III эрэмбэ	Оюун санааны хувьд ач тустай (олон нийтийн ухамсыг дээшлүүлэх боловсрол олгох гэх мэт)
IV эрэмбэ	Эдийн засагт ач тустай (хөдөлмөрийн зах зээл, хандив тусlamж оруулах)

Иргэдийн үзэж буйгаар ТББ-ын үйл ажиллагаа нь иргэд болон нийгэмд ач тустай гэж 53.0% нь үзэж байгаа бол 39.0% нь дунд зэрэг, үлдсэн 8.0% нь ач тусгүй гэж үздэг байна. Иргэдийн өгсөн үнэлгээний дундаж утга нь 3.54 байлаа.

## ДҮГНЭЛТ

### ТББ-ЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ТОО

- Төрийн бус байгууллагын хуулийн этгээдийн статус эрхзүйн баримт бичгүүдэд уялдаа холбоогүй, тодорхой бус байна. ТББ-ын төрөл, хэлбэрийн талаарх хууль эрх зүйн зохицуулалтын зөрчил нь ТББ-уудад ойлгомжгүй байдлыг бий болгож байгаагаас гадна ТББ-ын нэгдсэн бүртгэл мэдээлэл хөтлөх, түүнд дүн шинжилгээ хийх, салбарын бодлогод нэгдсэн мэдээлэл ашиглахад хүндрэл үүсгэж байна.
- Мөн түүнчлэн ТББ-ын төрөл, хэлбэрийн явцуу зохицуулалт, бүртгэлийн практик нь ТББ-уудын зохион байгуулалт, бүтэц, хэлбэр, үндсэн зорилго зэргийг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй байна.
- Түүнчлэн, ТББ, ИНБ, ашгийн төлөө бус хуулийн этгээд зэрэг зарчмын ялгаатай ойлголтуудыг бодлогын бөгөөд эрх зүйн баримт бичиг, практикт ашиглаж байгаа нь иргэний нийгмийн салбар, түүний хөгжлийн талаарх нэгдсэн ойлголт төрийн түвшинд ч, ТББ-уудын дунд ч байхгүй байгааг илтгэнэ. Иймд Иргэний нийгмийн хөгжлийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулснаар төр, иргэний нийгэм нэг цонхоор харж, нэг “хэлээр” ойлголцоход чухал нөлөөтэй байна.
- ТББ-ын тоо 1998 онд 1075 буюу хойш улсад бүртгэлтэй нийт байгууллагын 5.7 хувийг эзэлж байсан бол 2020 онд 10,806 буюу 9.7%-ийг эзэлдэг болж 2 дахин нэмэгдсэн нь иргэний нийгмийн салбарын сүүлийн 20 гаруй жилийн хөгжлийг илтгэж байгаа үзүүлэлт юм.
- Судалгаанд оролцсон ТББ-уудын тал нь гишүүнчлэлгүй буюу “сан”<sup>2</sup>-ийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна. Гэсэн хэдий ч эдгээрийн дийлэнх нь улсын бүртгэлд “ТББ Холбоо” гэсэн ангиллаар бүртгэгдэж байна. Судалгаанд хамрагдсан ТББ-уудын 46 орчим хувь нь гишүүнчлэлтэй бөгөөд 27.0 мянга гаруй хуулийн этгээд, 84.0 мянга гаруй хувь хүнд үйлчилгээ үзүүлж байна. Хувь хүнд үзүүлж буй үйлчилгээ нь аль ч насны иргэдэд чиглэж чадсан байгаа нь ТББ-уудыг хүртээмжтэй ажилладгийг харуулж байна.
- Гишүүнчлэлтэй эсэхээс үл хамааран ТББ-ууд дийлэнх нь нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж буй ТББ-ын 80 гаруй хувь нь нийгэм үйлчилдэг буюу нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага байна. Энэ нь ТББ-ууд нь нийтийн сайн сайхны тулд иргэдийн өөрсдийн санаачилгаар эвлэлдэн нэгдэж, байгууллага байгуулж, нийгмийн капиталыг бүрдүүлж, хөгжүүлж буй хэлбэр болохыг нотолж байна.
- Практик дээр гишүүнчлэлийн тухай ойлголт, зохион байгуулалт нь ТББ тус бүрд харилцан адилгүй байна. Тухайлбал, сонгодог холбооны хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас гадна нь хязгаарлагдмал эрх, үүрэг бүхий гишүүнчлэлтэй “зөвлөл” гэх мэт байгууллага байна.

### ТББ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ЧИГЛЭЛ, ХЭЛБЭР, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ

- Судалгааны дүнгээр ТББ-ууд нь маш олон чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа ба одоогийн ашиглагдаж буй үйл ажиллагааны ангилал нь ТББ-ын үйл ажиллагааны олон янз байдлыг бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй байна.

<sup>2</sup> Иргэний хуулийн ангиллаар

- Судалгааны дүнгээр боловсролын бусад үйлчилгээ (14.5%), нийгмийн хамгааллын үйлчилгээ (8.2%), байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа (6.1%) ТББ-ууд хамгийн түгээмэл байна.
- Үндэсний болон аймаг нийслэлийн түвшинд үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нь сургалт, судалгаа, зөвлөгөө, нөлөөлөл, мэдээллийн үйл ажиллагаа түлхүү хэрэгжүүлж байна. Харин баг, хороо, сум дүүргийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд нь ихэвчлэн тусlamж үйлчилгээ, сургалт, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ явуулж байна.
- Төрийн үйлчилгээний мониторинг, төсвийн хяналт, өмгөөлөл, сурталчилгаа зэрэг чиглэлийн үйл ажиллаагаа эрхэлдэг ТББ аль ч түвшинд маш цөөн байна.
- Судалгаад оролцсон ТББ-уудын 30.0% нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байна.
- ТББ-ын 93.6% нь анх бүртгүүлсэн үйл ажиллааны чиглэлээ өөрчлөөгүй буюу үйл ажиллааны чиглэл нь тогтвортой байгаа ч ТББ-уудын 18.0%-ийнх нь үйл ажиллаагаа нь тасалдаж байжээ. ТББ-уудын үйл ажиллагаа нь ихэвчлэн (91.9%) З сараас дээш хугацаагаар тасалдаж, 67.5%-д нь санхүүжилтийн асуудлаас, 35.0%-д нь бусад асуудлаас болж тасалдсан байна.
- ТББ-уудад үйл ажиллагаа тогтвортой явуулахад санхүүгийн (67.8%), төрийн дэмжлэг сул байдал болон хүнд суртал, дарамт шахалт (49.8%) хамгийн бэрхшээл учруулж байна.

### ТББ-ын засаглал, удирдлага

- ТББ-уудын 82.2% нь ямарваа нэг дотоод үйл ажиллааны дүрэм журмын хүрээнд ажиллаж байна. Гэвч ТББ-ууд нь засаглалын тогтолцооны хувьд харилцан адилгүй түвшний чадавхтай байна.
- Иргэний нийгмийн байгууллагуудын удирдах зөвлөлийн 87.4% хувийг хувь хүн харин үлдсэн хувийг төрөл бүрийн ААНБ-ын төлөөлөл эзэлж байна. Мөн ТББ-ын 70.2%-ийнх нь УЗ харьцангуй тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.
- ТББ-ын удирдах зөвлөлийн үйл ажиллааны идэвх нь тухайн ТББ-ын хэмжээ, чадавхаас хамаарч байна. Цөөн тооны ажилтантай (1-5 ажилтантай), орон нутагт үйл ажиллагаа явуулж буй жижиг ТББ-уудын хувьд УЗ нь жилд нэг эсвэл түүнээс цөөн удаа хуралдах, эсвэл огт үйл ажиллагаа явуулахгүй байх тохиолдол илүү байгаа бол 9 болон түүнээс дээш тооны ажилтантай ТББ-ын удирдах зөвлөл нь жилд 2 болон түүнээс олон удаа хуралдах нь түгээмэл байна.
- Үүсгэн байгуулагдаад удаагүй, үйл ажиллагаа нь бүрэн тогтвортроогүй, жижиг ТББ-уудад үүсгэн байгуулагч, удирдах зөвлөлийн бие бүрэлдэхүүн нь гүйцэтгэх удирдлагаа хэрэгжүүлдэг практик түгээмэл байгааг чанарын судалгаанаас мөн харж болно. Үүний гол шалтгаан нь эдгээр ТББ-уудад санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал байдгаас удирдлагын болон бусад ургсал зардлаа бууруулах шаардлагатай байдаг бөгөөд удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын энэхүү нийлмэл практик нь удирдлагын зардлаа бууруулах үндсэн арга, хэлбэр нь болж байна.
- Гүйцэтгэх удирдлагаас гадна ТББ-д дунджаар 5,7 ажилтан ажиллаж байна (хамгийн багадаа 1, хамгийн ихдээ 35 ажилтантай байна). Нийт ТББ-уудын 70,4% нь 5 болон түүнээс бага буюу дунджаас цөөн тооны ажилтантай байна. Харин 92.8% нь 1-9 ажилтантай байгаа нь ТББ-уудын хүний нөөцийн чадавх хангалттай бэхжээгүй байгааг бүрэн дүүрэн илэрхийлж байна.

- Нийт ТББ-уудын 75% нь 10 хүртэлх сайн дурын ажилтантай, харин 25% нь 10-аас дээш сайн дурынхантай ажиллаж байгаа нь ТББ-ууд сайн дурынхан болон сайн дурын үйл ажиллагааг өргөнөөр дэмжиж байгааг харуулж байна.
  - 2020 онд Сайн дурынхны байгууллагуудын сүлжээний 19.694 сайн дурынхан нийт 1,418,582 цаг сайн дураар ажиллаж, Монгол Улсын эдийн засагт 3,4 тэрбум төгрөгтэй дүйцэхүйц хувь нэмрийг оруулжээ.

### ТББ-ын санхүүжилт, татвар, тайлагналт

- ТББ-ын санхүүгийн чадавх бэхжээгүй, орлогын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий байна. ТББ 80.0% орчим нь өөрийн байргүй, мөн 80.0% орчим сүүлийн 3 жилийн орлого, зарлагын дундаж хэмжээ 0-50 сая төгрөг байна.
- Нийт зардлын 67.0%-ийг үйл ажиллагааны зардал, 8.6% нь захиргааны зардал байгаа нь ОУ-ын жишгээс бага дүн байна. Дундаж ТББ нь 50 хүртэлх сая төгрөгийн 8.6% буюу 4.3 сая хүртэлх төгрөгийг 3 жилийн хугацаанд удирдлагын буюу захиргааны зардалд зарцуулж байна. Иймд ТББ-уудад засаглалын хэт нарийн бүтцийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал байдаг нь харагдаж байна. Тиймдээ ч жижиг ТББ-ууд удирдлагын зардлаа бууруулах үүднээс удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага нь хосолсон буюу хавсарсан бүтэцтэйгээр ажиллаж байна.
- ГҮТББ-ын хувьд гишүүний татвар, хандиваас орлого бүрдүүлэх байдал нь түгээмэл бол НҮТББ нь иргэд, ААНБ-ын хандив, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого зэрэг нь орлогын эх үүсвэрийн нэлээд хувийг бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч ФБЯ-аас харахад хамгийн түгээмэл, бүх л төрлийн ТББ-уудад адил байгаа санхүүжилтийн эх үүсвэр ОУБ-ын санхүүжилт, тэтгэлэг, төслийн санхүүжилт байна.
- Сүүлийн 3 жилийн хугацаанд оролцогч байгууллагуудын 88.9% нь тайлан гаргаж, 11.1% нь санхүүжилт байхгүй, үйл ажиллагаа явуулаагүй, Х тайлан өгөх ёстой гэж мэдээгүй улмаас тайлан гаргаагүй байна. Нийт тайлан гаргаж буй байгууллагуудын 52.6% нь дэлгэрэнгүй тайлан, 36.3% нь Х тайлан гаргажээ.
- Тайлан гаргаж буй ТББ-ын 81.1% нь төрийн байгууллагад, 54.0% нь УЗ-д, 32.9% нь гишүүддээ гаргадаг байна.
- Судалгаанд хамрагдсан ТББ-ын 10.2% нь 108,970,000 төгрөгийн ААНБ-ын орлогын албан татвар, 23.6% нь 446,670,000 төгрөгийн ХХОАТ-ыг 2019 онд төлжээ. Мөн 2.5% нь үл хөдлөх хөрөнгийн татвар, газар ашигласны татварын 91,908,000 төгрөгийг төлсөн байна. Мөн 2019 онд ТББ-ын 23.0% нь НДШ төлжээ. ТББ дунджаар 986,000 төгрөгийн НДШ төлж, үүнээс ажил олгогч 455,000 төгрөг төлжээ.
- Судалгаанд оролцсон ТББ-ын дөнгөж 3.4% нь 2015-2019 онд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал эдэлжээ.
- ТББ-уудад хамгийн том санхүүгийн ачаалал нь татвар байдгийг чанарын судалгаа харуулж байна. Үүн дотроо НДШ, түүнтэй холбоотой торгуулийн төлбөр нь хамгийн түгээмэл бэрхшээл болж байна. НДШ-ээс гадна зарим байгууллагад үл хөдлөх хөрөнгийн татвар, гаалийн татвар гэх мэт татвар, хураамж мөн ачаалал үүрүүлж байна. ТББ-дад ноогдуулж буй татвар нь тэдгээрийн үйл ажиллагааны онцлогтой уялдаж байгаа нь эндээс харагдана.
- Аливаа төрлийн татвар нь ТББ-уудад хамгийн том дарамт болж байгаа бөгөөд удирдлагын зардлын томоохон хэсгийг эзэлж байна. Удирдлагын зардлын хувь хэмжээ бага, аливаа санхүүжүүлэгч байгууллагаас ТББ-д зөвхөн үйл ажиллагааны зардал холбогдох санхүүжилтийг олгодог. Эдгээр хүчин зүйлээс хамаарч ТББ нь

санхүүгийн чадавхийн хувьд бүрэн бэхжиж чадахгүй байна. Үүнийг ТББ-ын 79.6% нь төсөл, санхүүжилт зогсвол санхүүгийн эрсдлээс хамгаалах ямарваа нэг хуримтлалгүй байгаагаас харж болно.

## ТББ-ын үр нөлөө

- ТББ-үуд ихэвчлэн иргэд, олон нийт (72.5%), залуучууд (31.2%), хүүхдүүд (27.8%), эмэгтэйчүүд (26.2%), гэр бүлд (20.9%) чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс гадна нийгмийн олон янз бүлгүүд, байгаль, амьтан зэрэгт зориулан үйл ажиллагаа явуулж байна.
- Судалгаанд хамрагдсан 683 ТББ сүүлийн 3 жилд 784,730 хүнийг үйл ажиллагаа, үйлчилгээнд хамруулж, тэдний хэвлэн нийтлүүлсэн ном, товхимол, гарын авлагын тоо 56,524 мянгад хүрчээ. Тэд орон нутаг болон үндэсний хэмжээний 512 бодлогын баримт бичиг, эрх зүйн актад нэмэлт өөрчлөлт оруулж батлуулж, 2,850 удаа нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргаж, 8,526 судалгаа эрхлэн гүйцэтгэж, 3,782 газар нутаг, гол горхи, биологийн болон амьтны төрөл зүйлийг хамарсан үйл ажиллагааг хэрэгжүүлжээ.
- ТББ-ын нийгэмд гүйцэтгэж буй үүрэг, бүтээж буй үр нөлөөний цар хүрээ нь маш өргөн гэдгийг дээрх үр дүн харуулж байна. Хэдий тийм ч ТББ-ын үйл ажиллагааны үр нөлөө нийгэмд ил тод хэмжигдэхүйц биш, тайлагнах тогтолцоо сайн бүрдээгүй, төрийн байгууллагуудад өгдөг тайланд нь ямар ч урамшуулал дэмжлэг, эсвэл үнэлгээний механизм байхгүй байгаа нь иргэний нийгмийн салбарын бий болгож буй үр нөлөөг хэмжих, таниулахад бэрхшээл учруулж байна. Нийт байгууллагуудын 46.9% нь өөрсдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа үнэлдэг тогтолцоотой бол үлдсэн 53.1% нь үйл ажиллагаагаа үнэлдэггүй байна.

## Иргэний орон зай

- Иргэний суурь эрх, эрх чөлөөний хүрээнд таван асуудлыг үнэлүүлэхэд нийт дундаж индекс нь 3.03 гарч иргэний суурь эрх, эрх чөлөөний хэрэгжилтийн ерөнхий дүн хангалтгүй буюу дунд гэж үнэллээ. Хууль дээдлэх ёс болон, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхүүд хамгийн их зөрчигдэж байна гэж ТББ-үүд үзжээ. Түүнчлэн шилжин суурьшигчид болон малчдын эрхийн хамгаалалт хамгийн сүл байна гэж тэд үнэллээ.
- ИНБ-ын эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг нийт 8 асуултаар хэмжиж үзэхэд дунд зэрэг буюу 3.12 гэсэн дундаж үзүүлэлттэй гарав. Төрөөс ИНБ-д үзүүлэх дэмжлэг, ИНБ-ын төсвийн орчин, төрөөс иргэдийн саналыг хүлээн зөвшөөрөх байдал зэрэг хэрэгжилт хангалтгүй байна.
- ТББ-үуд хараат бусаар, чөлөөтэй бие даан үйл ажиллагаа явуулахад саад, бэрхшээл тулгарсаар байна: Тухайлбал:
  - ТББ-үүдүн тал хувь нь мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг ашигладаг ч 10 орчим хувь нь мэдээлэл авч чаддаггүй байна. Мэдээлэл авахад учирч буй хамгийн түгээмэл бэрхшээл нь хүнд суртал байна.
  - ТББ-үүдүн 40 гаруй хувь нь төрийн үйл ажиллагааг шүүмжилснээр аливаа дарамт шахалтад өртдөг байна.
  - Харин ТББ-үүдүн 13.0-18.0% нь цахим орчинд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлэх, үйл ажиллагаа явуулахад хязгаарлалттай тулгарч байна.
  - ТББ-үүдүн 7.2% нь эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах эрхээ хэрэгжүүлэхэд саад бэрхшээлтэй тулгарсан байна. Үүнд, хүнд суртал гаргах,

бүртгэхээс шалтгаангүй татгалзах, хууль бус шаардлага тавих зөрчлүүд гарч байна.

- ТББ-уудын 35.1% нь төрийн зүгээс дарамт шахалттай тулгардаг байна.
- Иргэний эрх чөлөө, оролцоог хязгаарлах, хуулийг үл дээдлэх үйл явцыг даван туулахын тулд 16.4% нь иргэний нийгэм бусад этгээдтэй хамтран олон талын оролцогчидтой стратеги боловсруулсан байгаа зэрэг нь иргэний орон зайнг бэхжүүлэх, түүнийг хамгаалахад ТББ болон олон талуудын хамтын ажиллагаа хөгжүүлэх шаардлага байсаар байгааг илтгэж байна.

### ТББ-ын талаарх иргэдийн санаа бодол

- Иргэдийн 72.0% ТББ-ыг дуу хоолойгоо нэгтгэж, өөрсдийн итгэл үнэмшил дээр суурилан эвлэлдэн нэгдэх гэж байгуулагддаг гэж тодорхойллоо. Мөн иргэдийн хувьд ТББ нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалж тэмцдэг (69.0%), олон нийт, эмзэг бүлэгт тусlamж, үйлчилгээ үзүүлдэг (63.0%) болон шударга бусын эсрэг жагсаж тэмцдэг (46.0%) ажлуудыг хийдэг гэж бодож байна.
- Олон улс, гадаадын тусlamж дэмжлэг (52.0%), иргэдийн (42.0%) болон хувийн хэвшлийн хандив тусlamжаар (38%) санхүүжилтээ бүрдүүлдэг гэж боддог байна.
- Иргэдийн 70 орчим хувь нь нийгмийн асуудлаар төрд нөлөөлдөг гэж үзсэн.
- Дийлэнх хэсэг нь асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий хүмүүс (57.0%) болон сайн дурынхан (55.0%) иргэний нийгмийн байгууллагад ажилладаг гэж хариуллаа.
- Иргэдийн 53.0% нь ТББ-уудыг иргэд болон нийгэмд тустай гэж боддог.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

"Баасанжав консалтинг" ХХК. (2017). ТББ-ын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа. 3.

"Орчны эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр. (2017 оны 07 02). Үндэсний хөтөлбөр. Эрүүл мэндийн яам: <http://www.mohs.mn/index.php/laws/21-ээс> Гаргасан

"Осол гэмтэл хүчирхийллээс сэргийлэх" үндэсний хөтөлбөр. (2017 оны 07 02). Үндэсний хөтөлбөр. Эрүүл мэндийн яам: <http://www.mohs.mn/index.php/laws/21-ээс> Гаргасан

"Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөр. (2017 оны 07 02). Үндэсний хөтөлбөр. Эрүүл мэндийн яам: <http://www.mohs.mn/index.php/laws/21-ээс> Гаргасан

(2007). *Бодлого боловсруулах, шийдвэр гаргахад үйл явц дахь ТББ-ын оролцоо.* УБ хот: ADMON.

(2020). *Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа.* УБ хот: МОНГОЛ УЛСИС.

IRIM судалгааны хүрээлэн. (2012). Төрийн байгууллагын вэб сайтын ил тод байдал,..

Ардчиллын боловсрол төв. (2005). Монгол Улс дахь төрийн бус байгууллагуудын мэдээлэл,..

Д.Сүхжаргалмаа . (огноо байхгүй). Монголын ТББ-ын санхүүжилтийн байдал. *ТББ-уудын нийгмийн салбарт хийсэн төсөл, хөтөлбөрүүдийн судалгаа .*

Загдсүрэн . (огноо байхгүй). Төрийн бус байгууллагын татварын эрх зүйн зохицуулалт. "Ашигийн төлөө бус байгууллын эрх зүйн зохицуулалт" сургалт семинар, (хуудсд. 1-1). УБ.

Засгийн газрын тогтоол . (2016). Хэрэглэгчийн эрхийг хамгаалах 233.

Засгийн газрын тогтоол 165. (2016 оны 3 21). Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай.

Засгийн газрын тогтоол 350. (2011). Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм.

Засгийн газрын тогтоолын хавсралт. (2008). Улсын онцгой комиссын ажиллах журам 11 -р тогтоол.

ЗГ-ын агентлагийн даргын тушаал. (2019 ). Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/260 дугаар тушаал.

Зохистой Хөгжлийн Жендер Төв. (2005). Төсвийн үйл явцад иргэний нийгмийн оролцоог хангах нь.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 71 дүгээр зарлиг. (1999). МОНГОЛ УЛСЫН ЦОЛ ХҮРТЭЭХ, ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ЖУРАМ.

МОНГОЛ УЛС-ЫН Засгийн Газар Сангийн яам. (2020). **ХҮҮХДИЙН МӨНГИЙГ 2020 ОН ДУУСТАЛ САР БҮР ОЛГОХООР ШИЙДВЭРЛЭЛЭЭ.**

МОНГОЛ УЛС-ЫН сангийн сайдын тушаал. (2020). ААН, Байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийг ашиглах журам.

МОНГОЛ УЛС-ЫН хууль. (2017 оны 1 26). *Монгол Улсын хууль. Гаргасан 2020 оны 7 24, Эрхзүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://www.legalinfo.mn/law/details/12453-aac>*

Н.Л.Жуковскаяя. (2018). *Монгол судлалын бүтээл цуврал. Нүүдэлчин Монголчууд: соёл уламжлал бэлэгдэл. Судар Өргөө.*

Нийгмийн даатгалын зөвлөл. (2017 оны 3 21). Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол: *Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан.*

Олон улсын хөдөлмөрийн байгууллага. (2020 ). *ОУХБ-ЫН ТӨВЧ БАРИМТ БИЧИГ - КОВИД19 ЦАР ТАХЛААС ҮҮДСЭН ХЯМРАЛ БА АЛБАН БУС ЭДИЙН ЗАСАГ: ШУУРХАЙ АРГА ХЭМЖЭЭ БА БОДЛОГЫН СОРИЛТУУД.*

Р.Нарангэрэл . (огноо байхгүй). *Монголын нийгэмд үйлчилдэг ТББ-ЫН ТӨЛӨВ .*

Сангийн сайдын тушаал №386. (2017). Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлан, түүний тодруулга бэлтгэх заавар. УБ хот.

Сонгуулийн ерөнхий хороо. (2020 оны 4 14). Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх журам. УБ хот.

Сонгуулийн Ерөнхий хорооны тогтоолын хавсралт 1. (2017 оны 5 4). Улс төрийн нам, төрийн бус байгууллагаас ард нийтийн санал асуулгын талаар ухуулга сурчилгаа хийх тухай журам.

Татварын ерөнхий газар. (2020). албан мэдээ.

Татварын ерөнхий газрын бүртгэл судалгааны алба. (2020). Тайлагналтийн мэдээлэл .

Төрийн байгуулалтын экспертийн зөвлөл-2020. (2020). *Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа . УБ.*

